



САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

2024 IX сар

№18

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2024 оны 9 дүгээр сар

АГУУЛГА

ХУРААНГУЙ	5
1. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ	9
1.1 Дэлхийн эдийн засгийн эрсдэл, эмзэг байдал	9
Шигтгээ 1. Хятадын үл хөдлөхийн салбарын хүндрэл	12
1.2 Дэлхийн санхүүгийн зах зээлийн эрсдэл, эмзэг байдал	13
Шигтгээ 2. Геополитикийн эрсдэлүүд	15
2. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН	16
2.1 Төлбөрийн тэнцэл	16
2.2 Өрх, иргэдийн санхүүд гарч байгаа өөрчлөлт	18
2.3 Аж ахуйн нэгж	22
2.4 Улсын төсөв	26
Шигтгээ 3. Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал	28
3. САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ	30
3.1 Банкны салбарын нөхцөл байдал	30
Шигтгээ 4. Банкны зээлийн төлөвийн түүвэр судалгааны үр дүн	33
3.2 Банкны салбарын эрсдэлийн шинжилгээ	35
Шигтгээ 5. Банкуудын эрсдэлийн хүлээлтийн судалгаа	41
3.3 Банкны бус санхүүгийн салбарын нөхцөл байдал	43
3.4 Банкны бус санхүүгийн салбарын эрсдэлийн шинжилгээ	50
Шигтгээ 6. Зээлийн мэдээллийн сангийн өгөгдөлд хийсэн шинжилгээ	52
4. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ	56
4.1 Банкны салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	56
Шигтгээ 7. Санхүүгийн мөчлөг	61
4.2 Банкны бус санхүүгийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	62

ХУРААНГУЙ

Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн 18 дахь дугаарыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос хамтран боловсруулж, олон нийтэд хүргэж байна. Уг тайлан нь 1) Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн эрсдэл, эмзэг байдал; 2) Дотоод эдийн засгийн орчин; 3) Санхүүгийн салбар, түүний эрсдэл, эмзэг байдал; 4) Санхүүгийн зохицуулагч байгууллагуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ гэсэн нийт 4 бүлгээс бүрдэнэ.

Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн эрсдэл, эмзэг байдал

Улс орнуудад хэрэгжүүлсэн цар тахлын дараах эдийн засгийг тогтворжуулах, өсөлтийг дэмжих бодлогын үр дүнд ажил эрхлэлт, орлого өссөн нь нийт эрэлтийг тэтгэж, улмаар 2023 оны дэлхийн эдийн засгийн өсөлт шинжээчдийн төсөөллөөс давж 3.2 хувьтай гарлаа. Гэвч ирэх 2 жилийн өсөлтийн төсөөлөл сүүлийн 20 жилийн түүхэн дунджаас бага түвшинд байхаар байна. Геополитикийн хурцадмал байдал, гео-эдийн засгийн хуваагдал, төсвийн дэмжлэг хумигдалт, санхүүжилтийн зардлын өсөлт, бүтээмжийн өсөлт бага байгаа зэрэг хүчин зүйлс үүнд нөлөөлөв.

Эрчим хүчний үнэ буурч, нийлүүлэлтийн сүлжээний дарамт суларсны зэрэгцээ хөгжингүй орнуудын төв банкууд мөнгөний хатуу бодлого тууштай хэрэгжүүлсэн нь дэлхий даяар инфляцын түвшин буурахад хүргэлээ.

Дэлхийн ихэнх улс орнууд өндөр инфляц, эрчим хүчний үнийн тогтворгүй байдал, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, геополитикийн хурцадмал байдал зэрэг олон сорилтуудтай тулгарсан нь нийт эрэлтийг сааруулах, улмаар дэлхийн аж үйлдвэрлэлийн өсөлт удаашралтай байхад нөлөөлөв. Дэлхийн

зах зээл дээр түүхий эдийн нийлүүлэлт тогтворжиж, хэвийн явагдаж эхэлсэн хэдий ч, аж үйлдвэрлэл буурч байгаа нь түүхий эдийн эрэлт, цаашлаад түүхий эдийн үнэ буурах дарамтыг нэмэгдүүлж болзошгүй юм.

Хөгжингүй орнуудад санхүүгийн нөхцөл суларсан хэдий ч савлагаа өндөр, эргээд чангарах эрсдэлтэй байна. Тухайлбал, АНУ бодлогын хүүгээ өндөр түвшинд удаан хугацаанд хадгалж байгаа нь хөдөлмөрийн зах зээлд сөргөөр нөлөөлж, цаашид эдийн засаг хүндрэх хүлээлт үүсгэв. Улмаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ буурч, хувьцаануудын үнэ эрчтэйгээр унаж, мөнгөний захын төлөв байдал муудсанаас шалтгаалан санхүүгийн нөхцөл энэ оны 8 дугаар сард эрчтэй чангарч, цаашид ч чангарах эрсдэлийг бий болгоод байна.

Түүнчлэн, БНХАУ-д дотоод эрэлт, аж үйлдвэрийн салбар бүрэн сэргээгүй, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт үргэлжилж байгаагаар холбоотойгоор тус улсын томоохон компаниудын хувьцаанаас бүрддэг Хонг Конгийн хөрөнгийн захын Hang Seng индекс эрчимтэй сулрав.

Дэлхийн томоохон эдийн засгуудын банкны салбарт тулгамдаж буй гол эрсдэл нь инфляц, мөнгөний бодлогын цаашдын төлөвөөс хамаарахаар байна. Ялангуяа олон улсын худалдааны хориг, геополитикийн хурцадмал байдлаас үүдэлтэй эрчим хүч, түлш шатахууны үнийн инфляц нь олон улсын эдийн засаг, мөнгөний бодлогын төлөв, цаашлаад банкны салбарын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Дотоод эдийн засгийн орчин

Эдийн засгийн сэргэлт, олон улсын зах зээл дэх түүхий эдийн үнийн өсөлт, түүхэн дээд түвшинд хүрсэн нүүрсний экспортын

нөлөөгөөр урсгал дансны болон төлбөрийн тэнцэл 2023 онд өндөр ашигтай гарлаа. Харин энэ оны эхний хагаст арилжааны болон хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад зээл, бондууд, своп хэлцлийн томоохон төлбөрүүд хийгдэж, валютын гарах урсгал өндөр байсан нь төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлөв. Ийнхүү томоохон төлөлтүүд хийгдсэнээр ирэх онуудад хүлээгдэж буй том дүнтэй Монгол Улсын гадаад өрийн эргэн төлөлтүүд бага болов.

2023 оны 12 дугаар сард Монголбанк Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлцлийн 1.5 тэрбум юанийн эргэн төлөлтийг хийсэн бөгөөд гадаад валютын албан нөөц 2024 оны 1 дүгээр улиралд түүхэн дээд хэмжээ буюу 5.2 тэрбум ам.долларт хүрч өссөн. Харин 2024 оны 4 дүгээр сард тус своп хэлцлийн 4.5 тэрбум юанийн эргэн төлөлтийг нэмж хийснээр 6 дугаар сарын байдлаар гадаад валютын албан нөөц 4.8 тэрбум ам.долларт хүрэв.

Хөдөлмөрийн захын төлөв сайжирч, өрхийн дундаж орлого эрчимтэй өссөн боловч хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын өсөлтөөс шалтгаалан өрхийн зарлага тэлж, нийт дүнгээрээ өрхийн орлого, зарлагын зөрүү сөрөг хэвээр байна. Өрхүүд санхүүгийн сөрөг зөрүүгээ зээлээр санхүүжүүлж, улмаар өрхийн секторын эмзэг байдал нэмэгдэх эрсдэлтэй.

Эдийн засгийн сэргэлтийг даган бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо нэмэгдсэний зэрэгцээ үйл ажиллагаагаа зогсоосон аж ахуйн нэгжүүдийн тоо буурлаа.

Эдийн засгийн идэвхжил, түүхий эдийн экспортын таатай нөхцөл байдал үргэлжилснээр төсвийн орлого бүрдүүлэлт өндөр гарч, төсвийн тэнцэл сайжирлаа.

Санхүүгийн салбар, түүний эрсдэл, эмзэг байдал

Банкны салбарын тэлэлт эрчимжиж, нийт актив болон зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 29.7 болон 31.5 хувиар нэмэгдлээ. Зээлийн өсөлтийн дийлэнх хэсгийг бизнесийн болон иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт бүрдүүлэв. Банкны салбар дахь зээлийн эх үүсвэрийг бизнесийн зээл рүү чиглүүлэх, бизнесийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээнүүдийн үр дүнд хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн өсөлт сэргэлээ.

Банкны салбарын нийт зээлд эзлэх хэрэглээний зээлийн хэмжээ 2023 оноос эргээд нэмэгдэж байна. Сүүлийн 2 жилд иргэдийн цалингийн орлого нэмэгдэж, улмаар ӨОХ-ны хязгаарлалттай зээл олголт өсөхийн зэрэгцээ хязгаарлалтгүй буюу хадгаламж барьцаалсан, тэтгэврийн зээл олголт ихээр нэмэгдлээ.

Банкны салбарын эрсдэл даах чадварын үзүүлэлтүүдийн хувьд 2024 оны 6 дугаар сарын байдлаар өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа, гадаад валютын позицын харьцаа Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байна. Түүнчлэн, 2023 болон 2024 оны эхний хагас жилд банкны салбар ашигтай ажиллаж, улмаар ашигт ажиллагааны үзүүлэлтүүд болох өөрийн хөрөнгийн болон активын өгөөж нэмэгдэв.

Нөгөөтэйгүүр, банк бус санхүүгийн байгууллагаас олгосон иргэдийн зээлийн хэмжээ 2019 оноос хойш хурдацтай нэмэгдсээр байна. Тодруулбал, 2024 оны 2 дугаар улирлын байдлаар ББСБ-ын иргэдийн зээлийн үлдэгдэл 4.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 49.3 хувиар, 2018 оны эцсээс 5.7 дахин нэмэгдлээ. Үүн дотроо өр, орлогын харьцааны хязгаарлалтгүй хэсэг

болох уламжлалт /финтекийн бус/ зээлийн өсөлт өндөр байгаа бөгөөд иргэдийн зээлийн үлдэгдлийн 60.7 хувийг эзэлж байна.

Банк болон ББСБ-аас давхар зээлтэй иргэдийн тоо болон зээлийн дүн хурдтай нэмэгдэж, санхүүгийн системд нийтлэг хамаарлаас үүдэлтэй эрсдэл тулгарч болзошгүй байна. 2023 оны 5 дугаар сартай харьцуулахад давхар зээлтэй иргэдийн банкны зээлийн үлдэгдэл 44.2 хувиар, ББСБ-ын зээлийн үлдэгдэл 53.4 хувиар, зээлдэгчдийн тоо 26.4 хувиар эрс нэмэгдсэн дүнтэй байна. Эдгээр иргэдийн хувьд сөрөг шок тулгарч, зээлийн эргэн төлөлтөд нь хүндрэл учрах тохиолдолд банк, санхүүгийн системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Санхүүгийн зохицуулагч байгууллагаас хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байгаа нь хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөх, хөрвөх чадвар сайжрах суурь нөхцөлийг бүрдүүллээ. Тухайлбал, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2024 оны эхний хагас жилийн байдлаар 11.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өссөн бол нийт арилжаалагдсан үнэт цаасны дүн өмнөх оны мөн үеэс 59.3 хувиар өслөө.

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-уудын нийт хөрөнгө болон зээл олголт эрчимтэй тэлж байна. Тодруулбал, нийт хөрөнгө 2024 оны 2 дугаар улиралд 5.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 45.9 хувиар, нийт зээлийн хэмжээ 4.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 47.7 хувиар тус тус өслөө.

Санхүүгийн зохицуулагч байгууллагуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Монголбанк банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор “Банкны

салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-ийг 2020 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Тус хөтөлбөрийн томоохон зорилтуудын нэг болох банкны хяналт, шалгалтын стандартыг сайжруулах ажлын хүрээнд Монголбанкны зүгээс гүйцэтгэл болон эрсдэлд суурилсан хяналт шалгалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэн ажиллаж байна.

Монголбанкнаас санхүүгийн системийн мөчлөгийн болон бүтцийн эрсдэлүүдийг тогтмол хянаж, мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдан бодит эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд банкнаас олгох иргэдийн хэрэглээний зээлд өр орлогын харьцаа (ӨОХ)-ны болон хугацааны хязгаарлалт тогтоох макро зохистой бодлогын арга хэмжээг 2019 оноос хойш хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэглээний зээлийн хэт өсөлтийг хязгаарлах, санхүүгийн системийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор ӨОХ-ны дээд хязгаарыг чангаруулав. Мөн банкуудын тэтгэврийн зээлийн эрсдэлийн жинг нэмэгдүүлэх, гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулах зэрэг шийдвэрийг гаргав.

Банк бус санхүүгийн салбарын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлд Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос голлон анхаарч ажиллаж байна. Тухайлбал, хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчны хүрээнд холбогдох журмуудад нэмэлт өөрчлөлт оруулахаар олон нийтээс санал авч, хэлэлцүүлгүүдийг зохион байгууллаа.

Даатгагчийн төлбөрийн чадварын тооцооллыг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн сайжруулж, эрсдэлд суурилсан аргачлал руу шилжүүлэх зорилгоор холбогдох журмыг баталж, Даатгалын багц хуулийн төслүүдийг батлуулах, “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр ажиллаж байна.


Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн хүрээнд бусдын хөрөнгийг удирдаж буй ББСБ-уудын эрсдэл даах чадвар, санхүү, төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Итгэлцлийн үйлчилгээний журам”, “Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх хуваарь”-ийг тус тус батлав.

1. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

1.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

Дэлхийн эдийн засгийн өсөлт харьцангуй тогтворжсон боловч өсөлтийг сааруулж болзошгүй сорилтууд хэвээр байна. 2023 оны дэлхийн эдийн засгийн өсөлт шинжээчдийн төсөөллөөс давж 3.2 хувь гарсан. 2024 болон 2025 оны өсөлт өнгөрсөн жилийн өсөлтийн орчимд хадгалагдах төлөвтэй байна (Зураг 1.1). Ирэх 2 жилийн өсөлтийн төсөөлөл түүхэн дунджаас¹ бага түвшинд байхаар байгаа нь геополитикийн хурцадмал байдал, гео-эдийн засгийн хуваагдал, төсвийн дэмжлэгийн хумигдалт, санхүүжилтийн зардал өндөр хэвээр, бүтээмжийн өсөлт бага байгаа зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж байна.

Зураг 1.1. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Олон улсын валютын сан

Тэмдэглэл: Төсөөлөл хийсэн хугацааг саарал суурь өнгөөр тодотгов.

Ихэнх улс орнуудад хэрэгжүүлсэн цар тахлын дараах эдийн засгийг тогтворжуулах, өсөлтийг дэмжих бодлогын үр дүнд 2023 онд ажил эрхлэлт, орлого өссөн нь нийт эрэлт, ялангуяа төсвийн зардал, өрхийн хэрэглээг дэмжиж, улмаар эдийн засгийн өсөлтийг тэтгэлээ.

2024 болон 2025 онд хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлт Евро бүсийн сэргэлтийн нөлөөгөөр бага зэрэг өсөх, харин хөгжиж буй орнуудын хувьд өсөлт тогтвортой байх төлөвтэй байна. 2024 оны 7 дугаар сард ОУВС-гийн шинжээчид Евро бүс, БНХАУ-ын энэ оны эдийн засгийн өсөлтийг өмнөх төсөөллөөс 0.1, 0.4 нэгж хувиар тус тус нэмэгдүүлж, 0.9, 5.0 хувь болгосон бол, АНУ-ын өсөлтийн төсөөллийг 0.1 нэгж хувиар бууруулж, 2.6 хувь болгов (Зураг 1.1). Харин нэг талаас зарим улс орнуудын эдийн засагт гарч буй эерэг өөрчлөлтүүд нөгөө талаас өсөлтийг удаашруулж болзошгүй сөрөг хүчин зүйлсийг харгалзан энэ оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 3.2 хувьд хэвээр хадгалав.

Эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, инфляцын түвшин буурч байгаа хэдий ч, геополитикийн хурцадмал байдал, хөшүүн суурь инфляц, хүүгийн түвшин өндөр хэвээр байгаа зэрэг нь энэ болон ирэх оны дэлхийн эдийн засгийн өсөлтийг сааруулж болзошгүй байна.

БНХАУ-д дотоод эрэлт сул байгаагийн зэрэгцээ үл хөдлөх хөрөнгийн салбарын уналтын улмаас хөрөнгө оруулалт удааширч байгаа нь тус улсын өсөлтийг сааруулж байна. БНХАУ-ын экспорт, импорт сэргэж дэд бүтэц, аж үйлдвэрлэлийн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа хэдий ч, гурав дахь жилдээ үргэлжилж буй үл хөдлөх хөрөнгийн салбарын уналтын нөлөөгөөр нийт хөрөнгө оруулалтын өсөлт зогсонги байдалтай байна. Хэрэглэгчдийн итгэл сул байгаа энэ үед дотоодын хэрэглээ ч мөн адил тогтворгүй хэвээр байгаа бөгөөд бөөний худалдааны салбарын өсөлт цар

¹ Дэлхийн эдийн засаг 2000-2019 онд дунджаар 3.8 хувийн өсөлттэй байсан.

тахлын өмнөх үеийн дунджаас доогуур түвшинд хүрлээ. Тус улсын Засгийн газрын зүгээс эрэлтийг дэмжих чиглэлд дэд бүтцийн төслүүдэд дэмжлэг үзүүлэх, цаашлаад төв банкны зүгээс бодлогын хүү болон заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулах зэрэг арга хэмжээг авсан.


Аж үйлдвэрлэл, экспортын сэргэлтийн нөлөөгөөр идэвхжиж, 2023 онд 5.2 хувь хүрээд байсан тус улсын эдийн засгийн өсөлт нь хөрөнгө оруулалт, төсвийн дэмжлэг, дотоодын хэрэглээ зэрэг хүчин зүйлсийн бууралтаас үүдэн удааширч, 2024 онд 5.0 хувь, 2025 онд 4.5 хувьд хүрч буурах хүлээлттэй байна. 2023 оны байдлаар хүн амын тоо хоёр дахь жилдээ дараалан буурч, төрөлтийн түвшин бага байгаа нь хүн ам зүйн асуудлыг дагуулж, потенциал өсөлтийг бууруулах төлөвтэй байна. Ийнхүү БНХАУ-ын нийт эрэлт, эдийн засгийн идэвхжил саарах эрсдэлтэй байгаа нь цаашлаад тухайн улсын үйлдвэрлэл, түүхий эдийн эрэлтийг бууруулж, улмаар худалдааны түнш орнуудад сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Олон улсын хэмжээнд инфляцын түвшин буурсаар байгаа хэдий ч ихэнх хөгжингүй орнуудын хувьд төв банкуудын зорилтот түвшнээс өндөр хэвээр байна. Дэлхий даяар инфляцын түвшин буурч, инфляц эрчимжиж эхэлснээс хойш 2023 оны эцсийн байдлаар анх удаа цар тахлын өмнөх түвшиндээ хүрээд байна. Инфляцын түвшин ийнхүү буурахад эрчим хүчний үнэ буурч, нийлүүлэлтийн сүлжээний дарамт суларсны зэрэгцээ хөгжингүй орнуудын төв банкууд мөнгөний хатуу бодлого тууштай хэрэгжүүлсэн нь голлон нөлөөллөө.

Хөгжингүй орнуудад өргөн хэрэглээний барааны үнэ эрчимтэй буурсан боловч үйлчилгээний инфляц өндөр хэвээр байна. Тухайлбал, АНУ-д эдийн засгийн идэвхжил тогтворжиж, орон сууцны үнэ хурдацтай

нэмэгдэж байгаа нь тус улсад үйлчилгээний болон суурь инфляцыг өдөөж байна. Харин АНУ-ын бүтээмжийн өсөлт нь цалингийн өсөлтөөс үүдэлтэй инфляцад үзүүлэх нөлөөллийг тодорхой хэмжээгээр бууруулж байгаа бол Евро бүсэд эсрэгээрээ бүтээмжийн бууралт нь эдийн засагт ажиллах хүчний зардлыг өсгөж, мөн үйлчилгээний болон суурь инфляцыг нэмэгдүүлээд байна.

Зураг 1.2. Инфляцын түвшин, төсөөлөл



Эх сурвалж: Олон улсын валютын сан

Тэмдэглэл: Төсөөлөл хийсэн хугацааг саарал суурь өнгөөр тодотгов.

2024 оны 7 дугаар сард ОУВС-гийн шинжээчид дэлхийн инфляцын төсөөллийг 2024 онд 5.9 хувь, 2025 онд 4.4 хувь байхаар тооцоод байна (Зураг 1.2).

Дэлхийн аж үйлдвэрлэлийн өсөлтийн сэргэлт удааширалтай байна. 2022 оны сүүлийн хагасаас удааширч эхэлсэн дэлхийн аж үйлдвэрлэл бага зэрэг сэргэж, 2024 оны 5 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өсөөд байна (Зураг 1.3). Дэлхийн ихэнх улс орнууд өндөр инфляц, эрчим хүчний үнийн тогтворгүй байдал, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, геополитикийн хурцадмал байдал зэрэг олон сорилтуудтай тулгарсан нь нийт эрэлтийг сааруулах, улмаар аж үйлдвэрлэлийн өсөлт удааширахад нөлөөлж байна.

Дэлхийн зах зээл дээр түүхий эдийн нийлүүлэлт тогтворжиж, хэвийн явагдаж

эхэлсэн хэдий ч аж үйлдвэрлэл буурч байгаа нь түүхий эдийн эрэлт, цаашлаад түүхий эдийн үнэ буурах дарамтыг нэмэгдүүлж болзошгүй юм. 2024 оны эхний хагаст газрын тосны томоохон нийлүүлэгч бүс нутаг болох Ойрх-Дорнодод мөргөлдөөн нэмэгдсэнээс үүдэн дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн хэлбэлзэл өндөр байв.

Манай улсын экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн нэг болох нүүрсний үнэ зах зээл дэх нөөц болон нийлүүлэлт нэмэгдсэнээс шалтгаалан энэ оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар буурч, цаашид ч буурах хүлээлттэй байна (Зураг 1.5). Геополитикийн хурцадмал байдал, төв банкуудын алтны худалдан авалт нэмэгдсэн зэргээс шалтгаалан зэс болон алтны үнэ өсөв. Дэлхийн аж үйлдвэрлэлийн эрэлт, металд суурилсан цэвэр эрчим хүчний хөрөнгө оруулалт нэмэгдэх төлөвтэй байгаа хэдий ч, Евро бүс болон БНХАУ-д аж үйлдвэрлэлийн идэвхжил сул, БНХАУ-д үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт буурсан нь эдгээр үнэт металын үнэ цаашид тогтвортой байх хүлээлтийг үүсгэж байна (Зураг 1.4).


Дэлхийн аж үйлдвэрлэл, эдийн засгийн өсөлт удааширч байгаа энэ үед дэлхийн худалдааны өсөлт мөн саарч байна. Тодруулбал, 2024 оны 5 дугаар сарын байдлаар дэлхийн худалдаа жилийн 0.2 хувиар өсөв (Зураг 1.3). Дэлхийн худалдааны хэтийн төлөв нь нийт эрэлт удаашрах, геополитикийн хурцадмал байдал нэмэгдэх, далайн тээврийн тасалдал зэрэг болзошгүй сорилтуудаас шалтгаалж байна. Энэ онд дэлхийн олон оронд улс төрийн сонгууль болж байгаатай холбоотойгоор худалдааны бодлоготой холбоотой тодорхойгүй байдал нэмэгдэж, улс орнууд илүү дотоод зах зээл рүү чиглэсэн бодлого хэрэгжүүлж, улмаар худалдааны хэтийн төлөв, эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Зураг 1.3. Дэлхийн аж үйлдвэрлэл болон худалдааны хэмжээний жилийн өөрчлөлт



Эх сурвалж: CPB Нидерланд улсын эдийн засгийн бодлогын шинжилгээний товчоо

Зураг 1.4. Алт, зэс, төмрийн хүдрийн үнэ (ам.доллар)



Эх сурвалж: Блүүмберг

Зураг 1.5. Байгалийн хий, газрын тос, нүүрсний үнэ (ам.доллар)



Эх сурвалж: Блүүмберг, Монголбанк

ШИГТГЭЭ 1. БНХАУ-ЫН ҮЛ ХӨДЛӨХИЙН САЛБАРЫН ХҮНДРЭЛ.

Төрийн байгууллагын хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлт, цар тахлын дараах хувийн хэрэглээний сэргэлт нь дотоодын нийт эрэлтийг дэмжсэнээр тус улсын эдийн засаг 2023 онд Засгийн газрын зорилтот түвшинд буюу 5.2 хувиар өслөө. Түүнчлэн, цэвэр экспорт эрчимтэй нэмэгдэж байгаа нь 2024 оны 1 дүгээр улиралд 5.3 хувийн эдийн засгийн өсөлттэй гарахад нөлөөлөв.

БНХАУ-ын үл хөдлөхийн салбарын хямрал эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн хэвээр байна. Засгийн газрын зүгээс бодлогын арга хэмжээнүүд авч байгаа хэдий ч үл хөдлөхийн салбарын борлуулалт, хөрөнгө оруулалт, шинэ төслүүдийн тоо 2022-2023 онд 25 орчим хувиар, 2024 оны эхний 5 сарын хугацаанд 10 орчим хувиар үргэлжлэн буурлаа (Зураг 1.6). Тухайлбал, урьдчилан зарагдсан боловч баригдаж дуусаагүй 3.5 сая орон сууцыг яаралтай ашиглалтад оруулах Засгийн газрын бодлогын зорилтын хувьд хэрэгжилт сайн байгаа боловч 2023 оны эцсийн байдлаар ашиглалтад ороогүй байгаа орон сууцнуудын тоо нь сүүлийн 1 жилд ашиглалтад орсон тооноос 8 дахин өндөр байна. Энэ нь худалдан авагч, хөрөнгө оруулагчдын итгэлийг муутгаж, борлуулалт эрчимтэй буурснаар томоохон компаниудыг дампууралд хүргэн, нийт салбарын хэмжээнд хямрал гүнзгийрэх болов. Нийт төсөл хэрэгжүүлэгч компаниудын 50 орчим хувь нь төлбөрийн чадварын хүндрэлд орсны зэрэгцээ 15 орчим хувь нь хөрвөх чадварын асуудалтай тулгарч эхлээд байна.

Зураг 1.6. БНХАУ-ын үл хөдлөхийн салбарын үзүүлэлтүүд, жилийн өөрчлөлтийн хувь



Эх сурвалж: Олон улсын валютын сан, Haver Analytics

Тэмдэглэл: Сүүлийн хугацаа нь 2024 оны 5 дугаар сар


Хятадын Ардын Банкнаас үл хөдлөхийн салбарыг хямралаас гаргах томоохон хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх болсноо зарлалаа. Орон нутгийн төрийн өмчит аж ахуй нэгжүүдийг борлогдоогүй байгаа орон сууцнуудаас худалдан авахад дэмжлэг үзүүлэх, иргэдийн амьжиргаанд нийцсэн хямд орон сууцаар хангах зорилготой 300 тэрбум юаны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тус банкны тэргүүн 2024 оны 5 дугаар сард зарлав. Гэвч шинжээчид болон барилгын компаниуд тус хөтөлбөрийн санхүүжилтийн хязгаарлагдмал байдал, хямд үнэтэй орон сууцнуудад чиглэсэн зэрэг нь хөрөнгө оруулалт, хөрвөх чадварын дутагдалд ороод буй тус салбарыг хямралаас гаргана гэдэгт эргэлзсэн хэвээр байна.

Эх сурвалж: Олон улсын валютын сан, Reuters

1.2 ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

Хөгжингүй орнуудад санхүүгийн нөхцөл суларсан хэдий ч савлагаа өндөр, эргээд чангарах эрсдэлтэй байна. АНУ-ын хувьд эрсдэлтэй хөрөнгийн өгөөжийн зөрүү багасаж, компаниудын хагас жилийн тайлангууд ашигтай гарснаар санхүүгийн нөхцөл 2024 оны эхний хагаст алгуур сулрав. АНУ бодлогын хүүгээ өндөр түвшинд удаан хугацаанд хадгалж байгаа нь хөдөлмөрийн зах зээлд сөргөөр нөлөөлж, цаашид эдийн засаг хүндрэх хүлээлт үүсгэж байна. Улмаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ буурч, хувьцаануудын үнэ эрчтэйгээр унаж, мөнгөний захын төлөв байдал муудсанаас шалтгаалан санхүүгийн нөхцөл энэ оны 8 дугаар сард эрчтэй чангарч, цаашид ч чангарах эрсдэлийг бий болгоод байна (Зураг 1.7).

Зураг 1.7. Санхүүгийн нөхцөлийн индекс




Эх сурвалж: Блүүмберг

2022 оны 7 дугаар сараас хойш бодлогын хүүгээ тасралтгүй өсгөөд байсан Европын Төв банк энэ оны 6 дугаар сард хүүгээ 0.25 нэгж хувиар бууруулж, хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал харьцангуй тогтвортой байгаа нь Евро бүсэд санхүүгийн нөхцөл сулрахад хүргэлээ (Зураг 1.8).

Хөрөнгийн зах зээлийн төлөв байдал сайжирч байгаа хэдий ч сүүлийн үед огцом савлагаа үүсээд байна. АНУ-ын S&P 500, MSCI Europe болон MSCI World индексүүд 2024 оны 6 болон 7 дугаар сард түүхэн дээд түвшинд хүрч өслөө (Зураг 1.8). 7 дугаар

сарын 31-ний өдөр АНУ-ын ХНБ бодлогын хүүгээ өндөр хэвээр хадгалах шийдвэр гаргаж, тус улсын эдийн засаг цаашид саарах эрсдэл үүсэхийн зэрэгцээ ажилгүйдлийн түвшин өндөр буюу цар тахлын үеийнхтэй ойролцоо байгаагаас шалтгаалан хөрөнгө оруулагчдын итгэл буурч, голлох индексүүдийн үнэ эрчтэйгээр унаад байна. Тухайлбал, дээрх мэдээлэл гарсны дараа 8 дугаар сарын 5-ны өдөр S&P 500 индекс оргил үеэсээ 9.3 хувиар, MSCI Europe индекс 7.8 хувиар унав.

Зураг 1.8. Хөрөнгийн захын гол индексүүд, 2006 = 100



Эх сурвалж: Блүүмберг

Дэлхийн томоохон эдийн засгуудын банкны салбарт тулгамдаж буй гол эрсдэл нь инфляц, мөнгөний бодлогын цаашдын төлөвөөс хамаарахаар байна. Олон улсын худалдааны хориг, геополитикийн хурцадмал байдлаас үүдэлтэй эрчим хүч, түлш шатахууны үнийн инфляц нь олон улсын эдийн засаг, мөнгөний бодлогын төлөв, цаашлаад банкны салбарын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Бизнесийн зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнийн уналт банкуудын активын чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Хурдтай хөгжиж буй орнууд (ЕМЕ)-ын хувьд хөрөнгийн зах зээлийн сэргэлт удаашралтай байна. БНХАУ-ын томоохон компаниудын хувьцаанаас бүрддэг Хонг Конгийн хөрөнгийн захын Hang Seng индекс


7 дугаар сарын эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар сулраад байна. Энэ нь БНХАУ-ын дотоод эрэлт, аж үйлдвэрийн салбар бүрэн сэргээгүй, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт үргэлжилж байгаатай холбоотой юм. Хурдтай хөгжиж буй орнуудын хувьцааны багц болох MSCI Emerging market индекс 2024 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар өссөн нь хөгжингүй орнуудын хөрөнгийн захын сэргэлттэй харьцуулахад бага байна.

Дэлхийн 4 дэх том эдийн засаг болох Япон улс 17 жилийн хугацаанд барьж байсан сөрөг хүүгийн бодлогоо дуусгавар болгож бодлогын хүүгээ 0.25 хувьд хүргэлээ. Удаан хугацаанд дефляцтай тэмцэж, сөрөг хүүгийн бодлого баримталж байсан Япон улсад цар тахал, геополитикийн зөрчил, томоохон улсуудын бодлогын хүүгийн өсөлт зэрэг дараалласан гадаад шокийн улмаас иений ханш ихээр унаж, инфляц үүсээд байв. Үүнээс үүдэн бодлого боловсруулагчид 2024 оны 3 болон 7 дугаар саруудад бодлогын хүүгээ 2 удаа нэмэгдүүлж 0.25 хувьд хүргэлээ. Зах зээлийн энэхүү өөрчлөлтөөс үүдэлтэйгээр Япон улсын 225 том компанийн хувьцааны багцаас бүрддэг Никкей индексийн савлагаа эрс нэмэгдэж, 2024 оны 7 дугаар сард түүхэн дээд түвшиндээ хүрч өссөн ч 8 дугаар сарын 5-ны Баасан гарагт 34.2 хувиар огцом уналаа. Энэ нь АНУ-ын Засгийн газраас гаргасан ажил эрхлэлтийн таагүй статистик мэдээлэл, тус улсад хямрал нүүрлэж болзошгүй, ам.доллартай харьцах иений ханш цаашид ч чангарч магадгүй хэмээн хөрөнгө оруулагчид болгоомжилж эхэлснээс үүдэлтэй ажээ. Нөгөөтэйгүүр, иений ханш чангарсны улмаас томоохон экспортлогч компаниудын ашиг буурсан явдал нь Никкей индекс унах нэг шалтгаан болов.

Дийлэнх улс орнуудын валютын ханш ам.долларын эсрэг суларсан хэвээр байна. Тухайлбал, 2018 оноос эхлэн эдийн засгийн

болон санхүүгийн хямралтай тулгарч буй Турк улс болон геополитикийн зөрчилдөөний гол оролцогч ОХУ-ын үндэсний мөнгөн тэмдэгтүүд нэг жилийн хугацаанд ам.долларын эсрэг хамгийн ихээр суларсан байна. Түүнчлэн, БНХАУ-ын эдийн засгийн тогтворгүй байдал, үл хөдлөх хөрөнгийн салбарын хүндрэл үргэлжилж, гадаадын хөрөнгө оруулалт татарч байгаа нь томоохон эдийн засагтай Азийн улс орнуудын мөнгөн тэмдэгт ам.долларын эсрэг сулрахад нөлөөлж байна (Зураг 1.9).

Зураг 1.9. Зарим орны валютын ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт



Эх сурвалж: Блүүмберг

Тэмдэглэл: 2023.07.31-ний өдрийн ханшийг 2024.07.31-ний өдрийн ханштай харьцуулав.

Хувийн зээлийн үйлчилгээ² эрчимтэй тэлж, дэлхийн санхүүгийн зах зээлд эзлэх хувь нэмэгдэж байгаа нь санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж байна. ОУВС-гийн тайланд³ дурдсанаар банк бус санхүүгийн байгууллагаас олгох аж ахуйн нэгжийн хувийн зээлийн үйлчилгээ хурдацтай тэлж, бусад зах зээлтэй өрсөлдөхүйц болж байна. Хувийн зээлийн хурдацтай өсөлт нь банкуудын томоохон зээлүүд дэх өрсөлдөөнийг нэмэгдүүлж, барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулах, зээлийн

² Хувийн зээл гэдэг нь үнэт цаас, өрийн хэрэгслийн санхүүжилт болон банкны зээлээс тусдаа ойлголт бөгөөд банкуудын хувьд эрсдэл өндөртэй, харин хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татахад хэт жижиг компаниудад хоёр талт гэрээнд үндэслэн хөвөгч хүүтэй зээл олгодог санхүүгийн зуучлагч байгууллагын үйлчилгээ юм.

³ ОУВС-гийн Дэлхийн санхүүгийн тогтвортой байдлын тайлан 2024 оны 4 сар.

гэрээний үнийн болон үнийн бус нөхцөл буюу андеррайтерийн стандартыг бууруулах,

ирээдүйд зээлийн алдагдалд орох эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй юм.

ШИГТГЭЭ 2. ГЕОПОЛИТИКИЙН ЭРСДЭЛҮҮД

Геополитикийн тогтворгүй байдал үргэлжлэн нэмэгдэж байгаа нь дэлхийн эдийн засаг, санхүүгийн салбарт шок үүсэх эрсдэлийг нэмэгдүүлсээр байна. Сүүлийн үед үүсээд буй Израйл-Хамасын мөргөлдөөн, Израйл болон Иран улсын зөрчилдөөн, ОХУ-Украины дайн, олон улсыг хамарсан геополитикийн зөрчил, хуваагдал нь гадаад орчны тодорхой бус байдлыг нэмэгдүүлсээр байна. Хар тэнгисийн далайн тээвэр сэргэж, зарим томоохон улс орнуудын ОХУ-ын түүхий эдээс хамаарах хамаарал багасч байгаа нь ОХУ-Украины дайны дэлхийн эдийн засагт үзүүлэх шууд нөлөөг бууруулж байгаа боловч Ойрх-Дорнодын хурцадмал байдал нь далайн тээвэр, худалдаа, түүхий эдийн зах зээлд шок бий болгож, бүс нутгийг хамарсан томоохон зөрчилдөөн бий болгож болзошгүй юм. Энэ нь жижиг, нээлттэй эдийн засагтай манай улсын хувьд гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын сумгаар дамжин санхүүгийн салбарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Зураг 1.10. Геополитикийн эрсдэлийн индекс, 2024 оны 7 дугаар сарын байдлаар



Эх сурвалж: Caldara, Dario and Matteo Iacoviello (2022)

Глобал түвшинд инфляцыг бууруулахад чиглэн хэрэгжүүлж буй бодлого, түүний үр дүнд геополитикийн тогтворгүй байдал сөргөөр нөлөөлж байна. ОХУ-Украины дайн, Ойрх-Дорнодын хурцадмал байдал нь дэлхийн нийлүүлэлтийн сүлжээ, түүхий эд болон хүнсний зах зээлд тасалдал, сөрөг шок бий болгон, улс орнуудын өндөр инфляцтай тэмцэх тэмцэлд сөргөөр нөлөөлж, мөнгөний бодлогын төлөвөө сулруулах хугацааг хойшлуулахад хүргэж байна. Түүнчлэн эдгээр геополитикийн зөрчилдөөнд шууд болон шууд бусаар оролцогч улс орнуудын санхүүгийн болон эдийн засгийн үйл ажиллагааг доголдуулах зорилготой кибер халдлагууд тохиолдох эрсдэл нэмэгдэх болов.

Сүүлийн жилүүдэд улс орнууд харьцангуй хаалттай гадаад худалдааны бодлого баримтлах болсон нь дэлхийн худалдаа, хөрөнгө оруулалтын интеграцыг сулруулж байна. Дэлхийн их гүрнүүдийн хоорондох зөрчилдөөн, талцал нь олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын хувьд хязгаарлалтуудыг нэмэгдүүлж, технологи болон ажиллах хүчний улс дамнасан шилжилт, хөдөлгөөнийг хязгаарлах хандлагатай байна. Европын Төв банкны тайланд дурдсанаар 2019-2023 оны хооронд улс орнуудын гадаад худалдааны хязгаарлалтууд эрс нэмэгдэж, БНХАУ болон АНУ-ын худалдааны дайны нөлөөгөөр бусад улс орнуудын эдийн засаг, хөрөнгө оруулалт, худалдааны тэнцэл муудах эрсдэл нэмэгдэх болов.

Дэлхийн эдийн засгийн нэгдмэл байдал улам бүр алдагдах нь макро санхүүгийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Эдийн засаг, санхүү, геополитикийн хувьд улс орнууд талцал үүсгэх болсон нь улс дамнасан хөрөнгө оруулалтыг бууруулах, эрсдэлээ хуваалцах боломжийг хумих, зээлдэгчид болон санхүүгийн байгууллагуудын хувьд эх үүсвэрийн зардлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Эх сурвалж: ОУВС-гийн Дэлхийн санхүүгийн тогтвортой байдлын тайлан 2024 оны 4 сар, Ирландын Төв банкны Санхүүгийн тогтвортой байдлын тойм 2024 оны 6 сар.

2. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2.1 ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

2023 онд төлбөрийн тэнцэл болон урсгал дансны тэнцэл уул уурхайн экспорт эрчимжиж, түүхэндээд хэмжээндээ хүрснээр өндөр ашигтай гарсан бол энэ оны эхний хагаст алдагдалтай гарав. Эдийн засгийн сэргэлт, олон улсын зах зээл дэх түүхий эдийн үнийн өсөлт, түүхэн дээд түвшинд хүрсэн нүүрсний экспортын нөлөөгөөр урсгал дансны болон төлбөрийн тэнцэл 2023 онд харгалзан 121.3 сая ам.доллар, 1457 сая ам.долларын ашигтай гарч байв. Харин 2024 оны эхний 6 сарын урьдчилсан гүйцэтгэлээр урсгал дансны алдагдал болон Монголбанк Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлцлийн 4.5 тэрбум юанийн эргэн төлөлт зэрэг томоохон гүйлгээнүүд нь төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлж, 57.3 сая ам.долларын алдагдалтай гарлаа (Зураг 2.1).

Үйлчилгээ болон барааны импорт тэлж, анхдагч орлогын гадагшлах урсгал өндөр байгаа нь урсгал данс алдагдалтай гарахад нөлөөллөө. Уул уурхайн экспорт өсснөөр урсгал дансны барааны худалдааны тэнцэл 2024 оны эхний хагаст 1865.2 сая ам.долларын ашигтай гарсан (Зураг 2.2). Урсгал дансны үйлчилгээний болон анхдагч орлогын тэнцэл алдагдалтай байснаар нийт урсгал данс 583.4 сая ам.долларын алдагдалтай гарав. Үйлчилгээний тэнцэл 1382.9 сая ам.долларын алдагдалтай гарахад ачаа тээвэрлэлт, аялал жуулчлал, болон бусад үйлчилгээний дансны тэнцэл алдагдалтай гарсан нь нөлөөлөв. Анхдагч орлогын дансны хувьд шууд хөрөнгө оруулалт болон зээлийн хүүгийн төлбөрийн гадагшлах урсгал өндөр байж, 1318.6 сая ам.долларын алдагдалтай гарлаа.


Чулуун нүүрсний экспортын хилийн дундаж үнэ буурсан ч экспортын биет хэмжээ өсөж, зэсийн баяжмал, алтны хилийн дундаж үнэ, биет хэмжээний өсөлтийн улмаас экспортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар өсөв. Гэхдээ, манай улсын экспортын гол түнш БНХАУ-ын эдийн засаг болон түүхий эдийн эрэлтээс уул уурхайн түүхий эдийн экспорт болон гадаад валютын орох урсгал өндөр хамааралтай хэвээр байна.

Зураг 2.1. Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/, урьдчилсан гүйцэтгэл



Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар
Тэмдэглэл: *2024 оны 1, 2 дугаар улирлын урьдчилсан гүйцэтгэл.

Зураг 2.2. Барааны худалдааны тэнцэл /сая ам.доллар/, урьдчилсан гүйцэтгэл



Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар


Монгол Улсын Засгийн газрын гадаад өр буурч, ирэх онуудад хүлээгдэж буй том дүнтэй гадаад өрийн эргэн төлөлтүүд бага байна. Энэ оны 2 дугаар улиралд арилжааны болон хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад зээл, бондууд, своп хэлцлийн томоохон төлбөрүүд хийгдэж, валютын гарах урсгал өндөр байсан нь сүүлийн 4 улирал дараалан ашигтай гарч байсан санхүүгийн данс тус улиралд 197.0 сая ам.долларын алдагдалтай гарахад хүргэлээ. Харин Оюу Толгойн далд уурхайн хөрөнгө оруулалт болон хувийн секторын гадаад зээлийн ашиглалт энэ оны эхний хагаст өндөр байснаар хөрөнгийн орох урсгал нэмэгдэж, санхүүгийн дансны тэнцэл хагас жилийн дүнгээр 660.3 сая ам.долларын ашигтай гарлаа (Зураг 2.3).

Төлбөрийн тэнцэл 6 улирал дараалан ашигтай гарснаар гадаад валютын албан нөөц 2024 оны 1 дүгээр улиралд түүхэн дээд хэмжээ буюу 5,249.8 сая ам.долларт хүрэв. 2022 оны 4 дүгээр улирлаас хойш нүүрсний экспорт эрчимжиж, валютын орох урсгал нэмэгдэн төгрөгийн ханш чангарах нөлөөг үзүүлж байна. Харин 2024 оны 4 дүгээр сард Монголбанк Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлцлийн 4.5 тэрбум юанийн эргэн төлөлт хийсэнтэй холбоотойгоор 6 дугаар сарын байдлаар гадаад валютын албан нөөц 4,838.8 сая ам.долларт хүрч буурав. Энэ нь сүүлийн 3 сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй барааны импортын 4.9 сарын хэрэгцээг хангах түвшин юм (Зураг 2.4).

Засгийн газрын зардал, иргэдийн хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлтөөс шалтгаалсан импортын тэлэлт төлбөрийн тэнцэлд ачаалал үүсгэж байна. Дэлхийн геополитикийн хурцадмал байдал, гео-эдийн засгийн хуваагдлаас шалтгаалан тодорхойгүй байдал үргэлжилж, экспортын түүхий эдийн

үнэ, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй хэвээр байна.


Зураг 2.3. Санхүүгийн данс, улирлаар /сая ам.доллар/



Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: *2024 оны 1, 2 дугаар улирлын урьдчилсан гүйцэтгэл.

Зураг 2.4. Гадаад валютын нөөц /сая ам.доллар/



Эх сурвалж: Монголбанк

2.2 ӨРХ, ИРГЭДИЙН САНХҮҮД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ

Өрхийн орлого, зарлага

Бодит цалингийн өсөлт өндөр түвшинд хадгалагдаж байна. Улсын дундаж цалин 2024 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар нэмэгдэж, 2.5 сая төгрөгтэй тэнцэж байна. Инфляцын түвшин буурч байгаагийн зэрэгцээ нэрлэсэн цалин өссөөр байгаа нь бодит цалингийн өсөлт өндөр түвшинд хадгалагдахад хүргэв. Тухайлбал, 2024 оны 2 дугаар улирлын байдлаар бодит цалин өмнөх оны мөн үеэс 23.3 хувиар өсөв (Зураг 2.5).

Өрхийн дундаж орлого болон дундаж зарлагын сөрөг зөрүү нэмэгдэж байна. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар өрхийн дундаж орлого өмнөх оны мөн үеэс 24.9 хувиар өссөн бөгөөд үүний дийлэнх хэсгийг цалин, тэтгэвэр, тэтгэмжийн орлогын өсөлт бүрдүүлж байна. Харин өрхийн зарлага 18.7 хувиар өссөн бөгөөд үүний дийлэнх хэсэг нь хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын өсөлтөөр тайлбарлагдаж байна. Гэсэн хэдий ч, нийт дүнгээрээ өрхийн орлого, зарлагын зөрүү сөрөг хэвээр байгаа нь өрхүүд санхүүгийн сөрөг зөрүүгээ зээлээр санхүүжүүлж, улмаар өрхийн секторын эмзэг байдал нэмэгдүүлэх эрсдэл дагуулж байна (Зураг 2.6).

Хөдөлмөрийн захын төлөв байдал сайжирч байна. Цар тахлын нөлөөгөөр эрчимтэй буурч 2021 оны 1 дүгээр улиралд 54.9 хувь хүрээд байсан ажиллах хүчний оролцооны түвшин өнгөрсөн оны сүүлийн хагасаас сэргэж, 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 62.2 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.6 нэгж хувиар нэмэгдэв. Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 58.6 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 2.3 нэгж хувиар нэмэгдлээ. Харин 2023 оны 4 дүгээр улиралд статистик бүртгэж эхэлснээс хойших хамгийн доод түвшинд буюу 3.9 хувь хүрээд


байсан ажилгүйдлийн түвшин тайлант улиралд 5.8 хувьд хүрлээ (Зураг 2.7).

Зураг 2.5. Нэрлэсэн болон бодит цалингийн өсөлт, инфляцын түвшин




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 2.6. Өрхийн дундаж орлого, зарлага болон зөрүү /мянган төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 2.7. Хөдөлмөрийн захын үзүүлэлтүүд



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Иргэдийн зээл, орон сууцны үнэ


2024 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар санхүүгийн байгууллагуудаас¹ олгосон иргэдийн зээлийн үлдэгдэл 27.8 их наяд төгрөгт хүрэв. Тодруулбал, иргэдийн нийт зээлийн 70.1 хувийг банкны салбарын зээл, 14.3 хувийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд олгосон ипотекийн зээл², 14.7 хувийг ББСБ-ийн зээл, 0.9 хувийг ХЗХ-ны зээл тус тус бүрдүүлж байна. Харин банканд хамаарах иргэдийн зээлийг зориулалтаар нь авч үзвэл 53.3 хувийг хэрэглээний зээл, 23.6 хувийг ипотекийн зээл, 17.4 хувийг ЖДҮ-ийн зээл эзэлж байна (Зураг 2.8).

Иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт эрчимжиж, иргэдийн нийт зээлийн өсөлтийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байна. 2024 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар санхүүгийн байгууллагуудаас олгосон нийт иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 34.7 хувиар өсөж, ДНБ-ийн 36.7 хувьтай тэнцэж байна. Энэхүү өсөлтийг бүрэлдэхүүнээр авч үзвэл 18.2 нэгж хувийг хэрэглээний зээлийн өсөлт бүрдүүлж байна. 2023 он гарсаар цалин, тэтгэврийг үе шаттайгаар нэмэгдүүлснээс шалтгаалан өрхийн нэрлэсэн орлого өсөж, улмаар өрхүүдийн өр-орлогын харьцааны хязгаарлалтын хүрээнд авах боломжит зээлийн дүн нэмэгдсэнээр банкны салбарын хэрэглээний зээлийн өсөлт эрчимжээд байна (Зураг 2.9).

Банк бус санхүүгийн байгууллагаас олгосон иргэдийн зээлийн хэмжээ 2019 оноос хойш хурдацтай нэмэгдлээ. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар ББСБ-ын иргэдийн зээлийн үлдэгдэл 4.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх


оны мөн үеэс 49.3 хувиар, 2018 оны эцсээс 5.7 дахин нэмэгдлээ. Үүнд нийлүүлэлтийн талаас ББСБ-уудын санхүүжилтийн эх үүсвэр тогтвортой нэмэгдсээр байгаа нь голлох нөлөөг үзүүлж байгаа бол эрэлтийн талаас технологийн дэвшлийн тусламжтайгаар ББСБ-аас зээл авахад хялбар болсны зэрэгцээ зохицуулалттай банкны зах зээлээс зээл авах шалгуураас давсан зээлдэгчид илүү зохицуулалтгүй ББСБ-уудын зах зээлээс зээл авах хандлагатай байна.

Зураг 2.8. Өрхийн өрийн бүтэц, их наяд ₮



Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 2.9. Иргэдийн зээлийн ДНБ-д эзлэх хувь болон жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

Улмаар Санхүүгийн зохицуулах хорооноос финтек зээлийн хэт өсөлтийг хязгаарлах зорилгоор уг төрлийн зээлийн бүтээгдэхүүнд 2023 оны эхнээс 70 хувийн өр, орлогын харьцаа тогтоон мөрдүүлж байна. Гэвч тайлант улиралд финтек зээлийн үлдэгдэл


¹ Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон Монголын ипотекийн корпораци.

² Монголын ипотекийн корпораци (МИК)-д шилжсэн зээл

нь нийт ББСБ-уудын зээлийн үлдэгдлийн 21.6 хувийг бүрдүүлж буйн зэрэгцээ нэг зээлдэгчид дунджаар 591.9 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 32 дахин бага үзүүлэлт юм. Иймд тус зохицуулалт нь ББСБ-аас иргэдэд олгох хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлахад нөлөөлөл бага байж болзошгүй юм.

Банкны салбараас иргэдэд олгосон хэрэглээний зээлийн үлдэгдлийн өр-орлогын харьцаа (ӨОХ) буурч байна. 2024 оны 6 дугаар сарын байдлаар банкнаас иргэдэд олгосон хэрэглээний зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж ӨОХ 50.4 хувьд хүрч, хэрэглээний зээлд ӨОХ-ны хязгаарлалт мөрдүүлж эхэлснээс хойш харьцангуй бага түвшинд хүрээд байна (Зураг 2.10). Гэвч банкны бус санхүүгийн салбар зохицуулалт дутмаг байгаагаас шалтгаалан зарим зээлдэгчид банкны салбарт мөрдүүлж байгаа иргэдийн хэрэглээний зээлийн ӨОХ-ны хязгаарлалтаас давуулан ББСБ-аас зээл нэмж авч байна. Банк болон ББСБ-ын давхар зээлтэй эдгээр иргэдийн хувьд дундаж ӨОХ 80 орчим хувь байгаа нь банкны салбарын дундаж ӨОХ-наас 30 нэгж хувиар өндөр байна (Дэлгэрэнгүйг Бүлэг 4.2-оос харна уу).


Зураг 2.10. Хэрэглээний зээлийн үлдэгдлийн дундаж өр, орлогын харьцаа



Эх сурвалж: Монголбанк

Ипотекийн зээл олголт нэмэгдэх төлөвтэй байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу хуримтлалын сангийн дансанд төвлөрөх эх үүсвэрээр орон сууцны хөтөлбөрийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлснээр ипотекийн зээлийн олголт эрчимжиж байна. Тухайлбал, 2024 оны 2 дугаар улирлын байдлаар иргэдийн ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар нэмэгдэж, 8.6 их наяд төгрөгт хүрээд байна (Зураг 2.11).

Зураг 2.11. Иргэдийн зээлийн бүрэлдэхүүн, их наяд ₮, /жил бүрийн 2 дугаар улирал/



Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо


Эдийн засгийг дэмжих 10 их наядын хөтөлбөр дуусгавар болсноор удаашраад байсан иргэдийн жижиг дунд үйлдвэрлэлийн зээл олголт эргэн сэргэж, тайлант хугацаанд 28.2 хувиар өслөө (Зураг 2.11).

Цалин, тэтгэврийн орлого өсөж иргэдийн зээлийн эргэн төлөлт сайжирсны зэрэгцээ нийт зээлийн үлдэгдэл эрчимтэй нэмэгдсэн нь санхүүгийн салбар дахь иргэдийн зээлийн чанар сайжрахад нөлөөлөв. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар санхүүгийн салбар дахь иргэдийн чанаргүй болон анхаарал хандуулах зээлийн нийт иргэдийн зээлд эзлэх хувь буурч, харьцангуй бага түвшинд хүрээд байна. Банк, ББСБ, ХЗХ-ны хувьд чанаргүй зээлийн хувь харгалзан 2.6 хувь, 5.9 хувь, 3.0 хувьд тус тус хүрч, буураад байна (Зураг 2.13).

Цар тахлын үед нэмэгдээд байсан нийт ипотекийн чанаргүй болон анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх хувь 2024 оны 2 дугаар улирлын байдлаар харгалзан 1.0 болон 1.3 хувьд хүрсэн нь сүүлийн 1 жилийн хугацаанд тогтвортой байгаа үзүүлэлт юм (Зураг 2.14).

Барилгын өртгийн индекс эрчимтэй буурч, цар тахлын өмнөх үеийн түвшинд хүрсэн бол орон сууцны үнэ сүүлийн 8 улирлын турш тогтвортой хадгалагдаж байна. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар барилгын өртгийн индекс өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өсөөд байгаа (Зураг 2.15) нь 1 жилийн өмнөх өсөлттэй харьцуулахад 22.9 нэгж хувиар бага үзүүлэлт юм. Барилгын өртгийн өсөлт ийнхүү саарахад төгрөгийн ханш гол валютуудын эсрэг алгуур чангарч, гадаад инфляц буурсан, дотоодын барилгын материалын гол түүхий эдүүдийн үнэ сүүлийн саруудад буурч байгаа нь голлох нөлөөг үзүүлж байна.

Зураг 2.12. Ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл болон хагас жилд олгосон, төлөгдсөн зээл /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Монголбанк

Ийнхүү барилгын өртөг буурч байгаа хэдий ч шинэ болон хуучин орон сууцны үнэ тайлант улиралд өмнөх улирлаас харгалзан 0.6 хувь болон 4.2 хувиар тус тус нэмэгдлээ (Зураг 2.15). Цалин, тэтгэврийн орлого өсөж, орон сууц худалдан авах эрэлт нэмэгдсэний зэрэгцээ ипотекийн зээлийн санхүүжилт,

зээл олголт нэмэгдэх төлөвтэй байгаа нь орон сууцны үнэ өсөх дарамтыг нэмэгдүүлж болзошгүй юм.

Зураг 2.13. Иргэдийн анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь /жил бүрийн 2 дугаар улирал/



Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: ББСБ-ын нийт чанаргүй зээлийн үзүүлэлтийг ашигласан болно.

Зураг 2.14. Ипотекийн зээлийн чанар



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.15. Орон сууцны үнэ болон өртгийн индекс



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Тэнхлэг зууч

2.3 АЖ АХУЙН НЭГЖ


Эдийн засгийн сэргэлтийг даган бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо нэмэгдсэний зэрэгцээ үйл ажиллагаагаа зогсоосон аж ахуйн нэгжүүдийн тоо буурлаа. Энэ оны 2 дугаар улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо 99.1 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар нэмэгдлээ (Зураг 2.16). Үүний дотор хөдөө аж ахуй, боловсруулах, тээвэр, үл хөдлөх, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдийн тоо бусад салбартай харьцуулахад илүү ихээр нэмэгдсэн байна.

Ихэнх салбарын идэвхжил нэмэгдэж байгаагаар холбоотойгоор үйл ажиллагаагаа түр болон бүрэн зогсоосон аж ахуйн нэгжийн тоо буурав. Тухайлбал, үйл ажиллагаагаа зогсоосон аж ахуй нэгжүүдийн тоо нь нэмэгдээд байсан хөдөө аж ахуй, үйлчилгээний салбаруудад аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа сэргээж байна. Тайлант улирлын байдлаар худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах салбарт үйл ажиллагаагаа зогсоосон аж ахуйн нэгжийн тоо харгалзан 14.3 хувь, 20.1 хувь, 15.8 хувь, 13.1 хувиар тус тус буурлаа (Зураг 2.17).

Уул уурхай болон түүнээс өндөр хамааралтай салбаруудын борлуулалтын орлого нэмэгдэж байна. Нүүрсний экспорт өмнөх оны өндөр түвшинд хадгалагдаж байгаагийн зэрэгцээ бусад эрдэс бүтээгдэхүүний олборлолт нэмэгдсэнээр уул уурхайн салбарын өсөлт, борлуулалтын орлого нэмэгдэв. Тухайлбал, уул уурхайн салбарын борлуулалтын орлого 20.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 23.9 хувиар нэмэгдсэн бөгөөд уул уурхайн салбараас өндөр хамааралтай худалдаа, тээврийн салбарын борлуулалтын орлого харгалзан 31.0 их наяд, 3.5 их наяд төгрөгт хүрч өмнөх

оны мөн үеэс 16.7 хувь, 24.8 хувиар тус тус өслөө (Хүснэгт 2.1).

Зураг 2.16. Бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо /мянга/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 2.17. Үйл ажиллагаагаа түр болон бүрэн зогсоосон аж ахуйн нэгжийн тоо /мянга/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 2.1 Эдийн засгийн салбаруудын борлуулалтын орлого /тэрбум төгрөг/

Салбар	2022.06	2023.06	2024.06	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Аж үйлдвэр	11699	21644	25604	3960	18.3%
Уул уурхай	8050	16646	20626	3980	23.9%
Боловсруулах	2804	3914	3779	-135	-3.5%
Цахилгаан, хий	750	971	1053	82	8.4%
Ус хангамж	95	113	148	35	31.0%
Худалдаа	20823	26616	31055	4439	16.7%
Тээвэр	1588	2793	3486	693	24.8%
Төмөр зам	325	526	595	69	13.1%
Агаарын тээвэр	150	358	444	86	24.0%
Авто зам	1113	1909	2447	538	28.2%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Банкны салбар дахь зээлийн эх үүсвэрийг бизнесийн зээл рүү чиглүүлэх, бизнесийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээнүүдийн үр дүнд хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн өсөлт сэргэлээ. Энэ оны 2 дугаар улирлын байдлаар хувийн байгууллагад шинээр олгосон зээл 7.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 52.5 хувиар өссөн нь 1 жилийн өмнөх өсөлттэй харьцуулахад 44.4 нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Үүний дотор эдийн засгийн голлох салбарууд болох уул уурхай, барилга, худалдаа, боловсруулах салбарт олгосон зээлийн өсөлт огцом нэмэгдэв (Зураг 2.18).

Хувийн байгууллагын төлөгдсөн зээл тайлант хугацаанд 5.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 43.6 хувиар өсөв. Энэхүү өсөлтийг салбаруудаар авч үзвэл 23.4 нэгж хувийг худалдаа, 5.0 нэгж хувийг барилга, 4.2 нэгж хувийг уул уурхай, 3.6 нэгж хувийг тээвэр, 7.4 нэгж хувийг бусад салбарын зээлийн эргэн төлөлтийн өсөлт тус тус бүрдүүлээ.

Эдийн засгийн дийлэнх салбаруудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс өссөн бөгөөд тэр дундаа уул уурхай, худалдаа, боловсруулах салбарын зээл голлон өсөж, бизнесийн зээлийн өсөлтийг тэтгэж байна.

Тайлант улиралд банкны салбар дахь хувийн байгууллагын нийт зээлийн өрийн үлдэгдэл 13.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.6 хувиар өсөв. Тус өсөлтийг салбаруудаар авч үзвэл 4.7 нэгж хувийг уул уурхай, 4.2 нэгж хувийг худалдаа, 3.4 хувийг боловсруулах салбарын зээлийн өсөлт бүрдүүлэв (Зураг 2.19).

Түүнчлэн, нийт зээлийн үлдэгдлийн 30.7 хувийг худалдаа, 16.3 хувийг боловсруулах, 15.0 хувийг барилга, 13.5 хувийг уул уурхай, 24.4 хувийг бусад салбарын зээл тус тус бүрдүүлж байна (Зураг 2.20). Харин улсын байгууллагын нийт зээлийн үлдэгдэл 221.9 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 55.5


хувийг тээвэр болон агуулах, 33.4 хувийг уул уурхайн салбарын зээл тус тус бүрдүүлж байна.

Зураг 2.18. Хувийн байгууллагын олгосон зээлийн өсөлт, салбаруудаар, хувиар




Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.19. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн өсөлт, салбаруудаар, хувиар



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.20. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл, салбаруудаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Эдийн засгийн тодорхой салбаруудад олгосон зээлийн төвлөрөл өндөр түвшинд хадгалагдсаар байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар хувийн байгууллагын нийт зээлийн өрийн үлдэгдлийн 75.6 хувийг эдийн засгийн гол дөрвөн салбар³ буюу худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл болон уул уурхайн салбарын зээл бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл банкны санхүүгийн зуучлал, зээлийн чанар, ашигт ажиллагаа эдгээр салбаруудаас өндөр хамааралтай хэвээр байна (Зураг 2.21).

Түүнчлэн, нийт хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн 42.9 хувь нь 5 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй 338 тооны дансанд төвлөрч байгаа нь банкны салбарт зээлийн төвлөрлийн эрсдэл өндөр байгааг илэрхийлж байна (Зураг 2.22).

Банкны систем дэх хувийн байгууллагын зээлийн чанар сайжирч байна. Хувийн байгууллагын чанаргүй зээлийн нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь энэ оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 4.3 нэгж хувиар буурч, 10.8 хувьд хүрлээ. Чанаргүй зээлийн хувийг салбаруудаар авч үзвэл 2.5 нэгж хувийг уул уурхай, 2.5 нэгж хувийг боловсруулах, 2.3 нэгж хувийг барилгын салбарын чанаргүй зээл тус тус бүрдүүлж байна (Зураг 2.23).

Түүнчлэн, уул уурхай, барилга, худалдааны салбарын чанаргүй зээлийн үлдэгдэл харгалзан 15.8 хувь, 24.4 хувь, 23.5 хувиар тус тус буурлаа.

Мөн тайлант улиралд чанаргүй зээлийн хувь харгалзан уул уурхайн салбарт 18.5 хувь, хөдөө аж ахуйн салбарт 16.6 хувь, барилгын салбарт 15.5 хувь, боловсруулах салбарт 15.3 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс харгалзан 15.7 нэгж хувь, 2.4 нэгж хувь, 3.8 нэгж хувь, 4.1 нэгж хувиар тус тус буурлаа (Зураг 2.24).


Зураг 2.21. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн төвлөрөл /салбараар/



Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Төвлөрлийн харьцааг хамгийн их хувь эзлэх 4 салбарын нийт дүнгээр тооцов.


Зураг 2.22. Хувийн байгууллагын зээлийн төвлөрөл, зээлийн дүнгээр /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: Хөтөлбөрийн болон хөнгөлөлттэй зээлийн дүнг хассан.


Зураг 2.23. Хувийн байгууллагын чанаргүй зээлийн хувь, салбараарх бүрэлдэхүүн



Эх сурвалж: Монголбанк

³ 2024 оны 2 дугаар улирлын байдлаар ДНБ-ийн 39.1 хувийг эдгээр 4 салбарын ДНБ бүрдүүлж байна.

Зураг 2.24. Хувийн байгууллагын чанаргүй зээлийн харьцаа, салбаруудаар




Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү харьцангуй тогтвортой байна. Өндөр инфляцын эсрэг мөнгөний хатуу бодлогыг 2022-23 онуудад тууштай хэрэгжүүлсэн нь банкны системд хүү нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлэв. Харин сүүлийн 2 улирал дараалан бодлогын хүүг бууруулсан хэдий ч банкуудын зээлийн хүү

өндөртүвшинд хадгалагдаж байна. Тухайлбал, 2024 оны 2 дугаар улирлын байдлаар хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.8 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувь, 2021 оны эцэстэй харьцуулахад 3.9 нэгж хувиар тус тус өндөр үзүүлэлт юм (Зураг 2.25).

Зураг 2.25. Олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү




Эх сурвалж: Монголбанк

2.4 УЛСЫН ТӨСӨВ

Нэгдсэн төсөв

Эдийн засгийн идэвхжлээс шалтгаалан төсвийн тэнцэл оны эхний хагасын байдлаар ашигтай гарлаа. 2024 оны эхний хагас жилийн Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 14.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 28.4 хувиар нэмэгдсэн бол нийт зардал 12.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны үеэс 43.5 хувиар нэмэгдлээ. Ингэснээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл 1.3 их наяд төгрөгийн ашигтай гарав (Зураг 2.26).

Зураг 2.26. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн гүйцэтгэл /жил бүрийн эхний хагас, тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн орлого уул уурхайн түүхий эдийн бүтээгдэхүүний экспортоос ихээхэн хамааралтай байна. Эдийн засгийн идэвхжил, түүхий эдийн экспортын таатай нөхцөл байдал үргэлжилснээр төсвийн орлого бүрдүүлэлт өндөр байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 30 орчим хувь нь уул уурхайн салбараас шууд болон шууд бусаар хамаарч байна. Монгол Улсын нүүрсний экспорт сэргэж, энэ оны эхний хагаст нүүрсний экспортын биет хэмжээ 39.4 сая тоннд хүрч, 39.1 хувиар нэмэгдлээ.


2024 оны эхний хагаст төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 28.4 хувиар өссөн бөгөөд үүнд ААН-ийн орлогын албан татварын өсөлт голлон нөлөөлөв (Хүснэгт 2.2).

Хүснэгт 2.2. Нэгдсэн төсвийн орлого, бүрэлдэхүүнээр /жил бүрийн эхний хагасын байдлаар, тэрбум төгрөг/

Орлого	2022.06	2023.06	2024.06	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
ААНОАТ	989	1,781	3,186	1,405	78.9%
АМНАТ	804	1,734	2,111	376	21.7%
НОАТ	1,805	2,182	2,777	595	27.2%
Нийгмийн даатгалын орлого	1,386	1,795	2,105	310	17.3%
Бусад орлого	3,018	3,566	4,020	454	12.7%
Нийт төсвийн орлого	8,002	11,059	14,199	3,140	28.4%

Эх сурвалж: Сангийн яам

Зураг 2.27. Нэгдсэн төсвийн зарлагын жилийн өсөлтийн бүрэлдэхүүн /жил бүрийн эхний хагас/



Эх сурвалж: Сангийн яам

Бараа үйлчилгээний зардал нэгдсэн төсвийн зардлын өсөлтийн ихэнх хэсгийг бүрдүүлж байна. Энэ оны эхний хагаст бараа үйлчилгээний зардлын бүрдэл хэсэг болох цалин хөлсний зардал ихээхэн нэмэгдсэн нь бусад зардал өсөхөд голлон нөлөөлөв (Зураг 2.27). Тухайлбал, цалин хөлсний зардал өмнөх оны мөн үеэс 171.8 хувиар өсжээ.

Улсын гадаад өр


Монгол Улсын гадаад өрийн дарамт өндөр хэвээр байна.

Монгол Улсын нийт гадаад өр 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 34.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны үеэс 5.5 хувиар өслөө. Нийт гадаад өрийн 21.8 хувь буюу 7.6 тэрбум ам.долларыг Засгийн газар, 3.2 хувь буюу 1.1 тэрбум ам.долларыг төв банк, 5.2 хувь буюу 1.8 тэрбум ам.долларыг хадгаламжийн байгууллага, 22.9 хувь буюу 8.0 тэрбум ам.долларыг бусад салбаруудын гадаад өр бүрдүүлж байгаа бол 46.7 хувь буюу 16.3 тэрбум ам.долларыг компани хоорондын зээллэг бүрдүүлж байна (Зураг 2.28). Түүнчлэн компани хоорондын зээллэгийн 68.7 хувь буюу 11.2 тэрбум ам.доллар нь Оюутолгой ХХК-д хамаарч байна.

2031 он хүртэл Монгол Улсын Засгийн газар нийтдээ 2.6 тэрбум ам.долларын бондын эргэн төлөлтийг хийх хуваарьтай байна.


Тодруулбал, 2026 оны 4 дүгээр сард Засгийн газар Номад бондын 600 сая ам.долларыг эргэн төлөх хуваарьтай байгаа бол 2027 онд Сенчюри-2027 бондын 500 сая ам.доллар, 2028 онд Сенчюри-2028 бондын 650 сая ам.доллар, 2029 онд Сенчюри-2029 бондын 350 сая ам.доллар, 2031 онд Сенчюри-2031 бондын 500 сая ам.долларын эргэн төлөлтийг тус тус хийхээр байна (Зураг 2.29).

Зураг 2.28. Монгол Улсын гадаад өрийн бүтэц /тэрбум ам.доллар/



Эх сурвалж: Сангийн яам

Зураг 2.29. Засгийн газрын гадаад бондын төлбөрийн хуваарь, сая ам.доллар /2024 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар/




Эх сурвалж: Сангийн яам

ШИГТГЭЭ 3. САНХҮҮГИЙН СИСТЕМИЙН ЭРСДЭЛИЙН ЗУРАГЛАЛ

“Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал” нь санхүүгийн системийн эмзэг байдлын ерөнхий дүр зургийг харуулах, бодлого боловсруулагч болон зах зээлд оролцогчдод зах зээлд үүсэж болзошгүй эрсдэлийн талаарх чиг хандлагыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилготой болно. Монгол Улсын санхүүгийн салбарын эмзэг байдлыг илтгэгч үзүүлэлтүүдийг i) макро эдийн засаг, ii) гадаад сектор, iii) мөнгөний зах, iv) хөрвөх чадвар, санхүүжилт, v) банкны салбарын ашигт ажиллагаа, vi) хөрөнгийн зах зээл гэсэн ангиллаар бүлэглэн, нийт 34 үзүүлэлтийг тодорхойлж, эрсдэлийн түвшинг жил, улирал, сарын давтамжтайгаар тооцож байна.

Сүүлийн 2 жил орчмын хугацаанд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт огцом нэмэгдсэнээр эдийн засгийн идэвхжил сэргэж эхэлсний зэрэгцээ эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, инфляцыг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого, зохицуулалтыг арга хэмжээний нөлөөгөөр санхүүгийн системийн эрсдэл эрчимтэй буурч, эрсдэлийн нэгдсэн индексийн утга харьцангуй бага түвшинд хүрсэн (Зураг 2.30).

Зураг 2.30. Санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индекс /2023 оны 2 дугаар улирлын байдлаар/



Эх сурвалж: Монголбанк, Судлаачийн тооцоолол

Тайлбар: Индексийн утга өсөх нь эрсдэл нэмэгдэхийг илэрхийлнэ

Эрсдэлийн түвшин нэмэгдсэн үзүүлэлтүүд /сүүлийн 3 сартай харьцуулахад/:


- **Бодит ДНБ өсөлт:** 2024 оны II улиралд бодит ДНБ-ий өсөлт 3.9%-д хүрч, өмнөх оны мөн үеэс 1.9 нэгж хувиар буурав. Тус өсөлтийн 1.8 нэгж хувийг уул уурхайн салбар, 7.9 нэгж хувийг бусад салбарын өсөлт бүрдүүлж байгаа бол хөдөө аж ахуйн салбар өсөлтийг 5.8 нэгж хувиар бууруулах нөлөөг үзүүлэв.
- **Бодит зээлийн хүү:** Инфляцын үргэлжлэн буурч байгаа хэдий ч зээлийн хүү өндөр түвшинд хадгалагдсаар байгаа нь тайлант хугацаанд зээлийн бодит хүү 11.6%-д хүрч өмнөх оны мөн үеэс 5.5 нэгж хувиар нэмэгдэхэд хүргэв.
- **Нийт зээл/ДНБ:** Тайлант хугацаанд нийт зээл ба ДНБ-ий харьцаа урт хугацааны трендээс 3.4%-иар өндөр байна. Тус харьцаа үзүүлэлт өндөр байх нь санхүүгийн системд мөчлөг дагасан эрсдэл хуримтлагдаж болзошгүйг илтгэдэг.
- **Зээл/Хадгаламж:** Зээлийн өсөлт эрчимжсэний нөлөөгөөр зээл, хадгаламжийн харьцаа тайлант хугацаанд 1.38 болж, өмнөх оны мөн үеэс 5.6%-иар нэмэгдэв. Тухайлбал, зээл болон хадгаламж харгалзан 30.9% болон 23.8%-иар тус тус өслөө. Тус харьцаа үзүүлэлтийн утга хэт өндөр байх нь банкны системээс эх үүсвэр татагдахад хөрвөх чадварын хүндрэлд орох эрсдэл өндөр байгааг илтгэнэ.
- **Төв банкнаас банкны системд олгосон зээл, санхүүжилт:** Төв банкнаас банкны системд олгосон зээлийн хэмжээ 2.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 40.4%-иар нэмэгдлээ. Гэвч үүний 22.1 нэгж хувийг ипотекийн хөтөлбөрийн зээлийн санхүүжилтийн өсөлт бүрдүүлж байна.
- **Өөрийн хөрөнгийн хүрэлцээний түвшин:** Тайлант хугацаанд банкны системийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний түвшин өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар буурч, 15.2%-д хүрсэн нь 2022 оны 9 сараас хойших хамгийн бага үзүүлэлт болов.

3. САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ

3.1 БАНКНЫ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Банкны салбарын нийт активын хэмжээ үргэлжлэн өсөв. Банкны системийн нийт актив 2024 оны 2 дугаар улирлын эцэст өмнөх оны мөн үеэс 14.3 их наяд төгрөгөөр буюу 29.7 хувиар, харин оны эхнээс 5.2 их наяд төгрөгөөр буюу 9.2 хувиар өсөж, 61.9 их наяд төгрөгт хүрлээ. Энэхүү өсөлт нь мөнгөн хөрөнгө болон зээлийн өсөлтөөр голчлон тайлбарлагдаж байна. Тухайлбал, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2.5 их наяд төгрөгөөр буюу 24.2 хувиар өсөж 12.9 их наяд төгрөгт хүрэв. Харин банкуудын ТБҮЦ дахь хөрөнгө оруулалтын дүн өмнөх оны мөн үеэс 2.9 их наяд төгрөгөөр буюу 41.0 хувиар, оны эхнээс 1.2 их наяд төгрөгөөр буюу 13.0 хувиар өсөж 10.0 их наяд төгрөгт хүрээд байна. Түүнчлэн, банкны системийн нийт зээлийн эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 34.3 хувиар, өмнөх улирлаас 24.5 хувиар өсөж, 31.3 их наяд төгрөгт хүрэв (Зураг 3.1).


Зураг 3.1. Банкны системийн активын бүтэц, өөрчлөлт /их наяд төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын нийт активын 50 хувийг зээл бүрдүүлж байна. Зээл олголт эрчимжиж, зээлийн идэвхжил нэмэгдсэнээр зээлийн нийт активт эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар өсөж 50.5 хувьд хүрэв. Мөнгөн хөрөнгийн хэмжээ нийт активын 20.8 хувь, ТБҮЦ дахь хөрөнгө оруулалт 16.1 хувь, ЗГҮЦ дахь хөрөнгө оруулалт 2.6 хувь, бусад хөрөнгө 10.0 хувийг тус тус бүрдүүлж байна (Зураг 3.2).

Зураг 3.2. Банкны системийн активын бүтэц



Эх сурвалж: Монголбанк

Зээл, түүний өөрчлөлт


Бизнесийн зээлийн өсөлт нь нийт зээлийн өсөлтийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байна. Банкны салбарын нийт зээлийн үлдэгдэл (эрсдэлийн сангаар цэвэршүүлээгүй дүн) 2024 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 33.3 их наяд төгрөг байна. Зээлийн үлдэгдэл жилийн 31.5 хувиар өссний 13.6 нэгж хувийг бизнесийн зээл, 11.3 нэгж хувийг иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт тус тус бүрдүүлсэн байна (Зураг 3.3). Эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөрийн нөлөөгөөр 2022 оны эхний хагас жилд өндөр өсөлттэй байсан зээлийн өсөлт 2022 оны 2 дугаар улирлаас

эхлэн тогтмол саарсан ч 2023 оны 2 дугаар улирлаас 2024 оны 2 дугаар улирлыг дуустал тасралтгүй өсөж, нийт активын өсөлтөд эерэг нөлөө үзүүлсэн.

Зээлийн үлдэгдлийг эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад иргэдийн зээл 37.9 хувиар буюу 4.0 их наяд төгрөгөөр өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт болов. Түүнчлэн, үл хөдлөх салбарын зээл 45.8 хувиар буюу 1.6 их наяд төгрөгөөр, худалдааны салбарын зээл 18.3 хувиар буюу 993.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Барилгын салбарын зээл хамгийн бага хувиар буюу 8.1 хувиар өсжээ. Түүнчлэн, 2023 онд агшсан уул уурхайн


салбарын зээл жилийн 37.3 хувийн буюу 521.2 тэрбум төгрөгийн өсөлт үзүүллээ (Зураг 3.4).

Зураг 3.3. Зээлийн үлдэгдэл, түүний өөрчлөлт /их наяд төгрөг, хувиар/



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.4. Эдийн засгийн голлох салбаруудын зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/, зээлийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн чанар


Чанаргүй зээлийн хувь 2016 оноос хойших хамгийн бага түвшинд хадгалагдаж байна.

2024 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар нийт зээлийн 91.1 хувь буюу 30.3 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 3.6 хувь буюу 1.2 их наяд төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 5.3 хувь буюу 1.8 их

наяд төгрөгийн зээл чанаргүй ангилалд тус тус ангилагдаж байна (Зураг 3.5, Зураг 3.6). Банкны системийн чанаргүй зээлийн үлдэгдэл 2024 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 14.7 хувь буюу 302.5 тэрбум төгрөгөөр буурахын зэрэгцээ нийт зээлийн үлдэгдэл өсснөөр чанаргүй зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар буурсан (Зураг 3.5).

Иргэдийн зээлээс бусад салбарын чанаргүй зээлийн хэмжээ буурсан. Чанаргүй зээлийн жилийн өөрчлөлтийг эдийн засгийн салбараар авч үзвэл уул уурхайн салбарын чанаргүй зээл өмнөх оны мөн үеэс 114.2 тэрбум төгрөгөөр буюу 28.1 хувиар, худалдааны салбарын зээл 49.6 тэрбум төгрөгөөр буюу 15.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин иргэдийн чанаргүй зээлийн дүн өмнөх оны мөн үеэс 10.2 тэрбум төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна (Зураг 3.7).


Зураг 3.5. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк


Банкны системийн нийт чанаргүй зээлийн 28.1 хувийг иргэдийн, 58.9 хувийг том болон дунд аж ахуйн нэгжийн, 13.0 хувийг жижиг, бичил үйлдвэрлэл эрхлэгчдийн чанаргүй зээл бүрдүүлж байна.

Зураг 3.6. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.7. Тухайн салбар дахь чанаргүй болон анхаарал хандуулах зээлийн хувь




Эх сурвалж: Монголбанк

Эрсдэлийн сангийн хүрэлцээ

Банкны системийн зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 2.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар буюу 8.8 тэрбум төгрөгөөр буурсан байна. Эрсдэлийн сан болон чанаргүй зээлийн харьцаа буюу эрсдэлийн сангаар чанаргүй зээлийг барагдуулах хүрэлцээ банкны системийн хувьд 114.0 хувь байна (Зураг 3.8).

Зураг 3.8. Зээлийн эрсдэлийн сан, чанаргүй зээлийн харьцаа /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

ШИГТГЭЭ 4. БАНКНЫ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ҮР ДҮН¹

Зээлийн нөхцөл: 2024 оны 2 дугаар улирлын байдлаар банкуудын ААН болон иргэдийн зээлийн нөхцөл сүүлийн хоёр улирлын турш бага зэрэг суларсан байна. Том банкууд сүүлийн хоёр улиралд зээлийн хүүг бууруулах, барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулах, хугацааг уртасгах, хүүний бус шимтгэлийг бууруулах зэргээр ААН-ийн зээлийн нөхцлөө бага зэрэг сулруулсан бол иргэдэд олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, барьцаа хөрөнгийн шаардлагыг бууруулах зэргээр иргэдийн зээлийн нөхцөлийг сулруулжээ. Харин дунд болон жижиг банкууд зээлийн нөхцлөө хэвээр үлдээв. Ирэх улиралд том банкууд ААН, иргэдийн зээлийн нөхцлөө бага зэрэг сулруулах төлөвтэй байгаа бол дунд, жижиг банкууд зээлийн нөхцлөө хэвээр үлдээх хүлээлттэй байна (Зураг 3.9).


Зээлийн шалгуур: Тайлант хугацаанд том банкууд ААН-ийн зээлийн шалгуураа бага зэрэг сулруулж, иргэдийн зээлийн шалгуураа хэвээр хадгалсан байна. Харин дунд, жижиг банкууд зээлийн шалгууртаа өөрчлөлт оруулаагүй байна. Том банкууд хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарт олгох зээлийн шалгуураа бага зэрэг сулрууллаа (Зураг 3.10). Үүнд эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал сайжирсан, эх үүсвэрийн зардал буурсан нь голлон нөлөөлөв. Ирэх улиралд банкууд ААН, иргэдийн зээлийн шалгуураа бага зэрэг чангаруулах хүлээлттэй байна.

Зээлийн эрэлт: Тайлант хугацаанд банкууд ААН-ийн зээлийн эрэлтийн дундаж индекс нэлээд нэмэгдсэн мужид байгаа бол иргэдийн зээлийн эрэлтийн дундаж индекс бага зэрэг нэмэгдсэн үзүүлэлттэй байна (Зураг 3.11). Тухайлбал, том банкуудын ААН-ийн зээлийн эрэлт ихээхэн нэмэгдэж, иргэдийн зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдсэн байна. ХАА, боловсруулах үйлдвэр, худалдаа үйлчилгээний салбарын ААН-ийн зээлийн эрэлт өндөр байлаа. Үүнд эргэлтийн болон үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын зээлийн хүсэлт нэмэгдэж, ААН-ийн зээлийн хүүний ерөнхий түвшин буурсан нь голлон нөлөөлжээ. Иргэдийн зээлийн хувьд малчны зээл болон автомашины зээлээс бусад төрлийн зээлийн эрэлт нэлээд нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэрэглэгчдийн итгэл нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Түүнчлэн, ирэх улиралд зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэх хүлээлттэй байна. Ялангуяа том банкууд зээлийн эрэлт бага зэрэг нэмэгдэхээр байгаа бол дунд болон жижиг банкууд зээлийн эрэлт өөрчлөгдөхгүй гэж үзжээ.


¹ Эх сурвалж: Банкны зээлийн төлөвийн 2023 оны II улирлын түүвэр судалгааны тайлан. Монголбанк (2023).

Зээлийн нийлүүлэлт: 2024 оны 2 дугаар улирлын байдлаар банкууд ААН, иргэдийн зээлийн нийлүүлэлтээ эрчимтэй нэмэгдүүллээ. Улмаар ирэх улиралд банкууд ААН, иргэдийн зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Тухайлбал худалдаа үйлчилгээ, ХАА, боловсруулах үйлдвэрийн салбарын ААН-ийн зээлийн нийлүүлэлтээ өсгөх төлөвтэй байна. Харин иргэдийн зээлийн хувьд цалингийн, малчны болон бизнесийн зээлийн нийлүүлэлтээ нэлээд нэмэгдүүлэх хандлагатай байна.


Зураг 3.9. Зээлийн ерөнхий нөхцөлийн индекс



Зураг 3.10. Зээлийн шалгуурын индекс



Зураг 3.11. Зээлийн эрэлтийн индекс



Эх сурвалж: Монголбанк, Судалгаа статистикийн газар

3.2 БАНКНЫ САЛБАРЫН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

3.2.1 Банкны салбарт үүсэж болзошгүй эрсдэлийн талаар


Банкны салбарын тоон мэдээлэл болон зохистой харьцааны үзүүлэлтүүдэд тулгуурлан банкны системийн эрсдэлийн нэгдсэн индексийг тооцдог бөгөөд тус индекс нь 2024 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 0.26 болж, өмнөх оны мөн үеэс 0.03 нэгжээр нэмэгдсэн нь банкны системийн эрсдэл бага зэрэг нэмэгдсэнийг илтгэж байна (Зураг 3.12, 3.13).

- 1. Зээлийн эрсдэл.** Эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, нийлүүлэлтийн доголдол арилснаар инфляц буурч, гадаад орчны эрсдэл багассан нь зээлийн эрсдэлийг бууруулах, чанаргүй зээлийн эргэн төлөлт нэмэгдэх нөлөө үзүүллээ.
- 2. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар.** Мөнгөн хөрөнгийн өсөлт өндөр байгаагаас үүдэн банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа өмнөх оны мөн үеэс 3.7 нэгж хувиар нэмэгдэж 40.4 хувьд хүрэв.
- 3. Ашигт ажиллагаа.** Энэ оны эхний хагас жилд банкны салбар 909.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 303.1 тэрбум төгрөгөөр өндөр байна. Улмаар ашигт ажиллагааны

үзүүлэлтүүд болох өөрийн хөрөнгийн болон активын өгөөж харгалзан 29.0 болон 3.1 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 6.0 болон 0.5 нэгж хувиар тус тус өслөө.


4. **Зах зээлийн эрсдэл.** Банкны системийн нийт гадаад валютын позицын харьцаа үзүүлэлт -7.8 хувь буюу Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байна. Түүнчлэн, энэ оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад гадаад валютын зээл 36.8 хувиар өссөн бол гадаад валютын хадгаламжийн дүн 12.4 хувиар буурсан нь гадаад валютын зээл хадгаламжийн харьцаа өмнөх оны мөн үеэс 18.3 нэгж хувиар өсөхөд нөлөөлжээ.
5. **Өөрийн хөрөнгийн хүрэлцээ.** Банкны системийн нийт өөрийн хөрөнгө, 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд өмнөх оны мөн үеэс тус бүр 1.6 нэгж хувиар буурч, 15.2 хувьд хүрсэн буюу Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байна.

Зураг 3.12. Банкны системийн эрсдэлүүд
/Дэд бүлгээр, 2024-6 сар/



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.13. Эрсдэлийн түвшин



Эх сурвалж: Монголбанк

3.2.2 Банкны салбарын хэрэглээний зээлийн өсөлт


Монголбанкнаас иргэдийн хэрэглээний зээлийн өсөлтийг зохистой түвшинд хадгалах, өрхийн өрийн дарамтыг бууруулах болон банкны системд эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор банкнаас олгох хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцаа (ӨОХ) болон хугацааны хязгаарлалт тогтоон 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлж эхэлсэн билээ. Тус арга хэмжээний үр нөлөөгөөр хэрэглээний зээлийн өсөлт 2019 оноос хойш харьцангуй тогтворжиж, шинээр олгосон хэрэглээний зээлийн хугацаа богино болсон ба хэрэглээний зээлтэй иргэдийн өр, орлогын харьцаа буурч хязгаарлалтаас доогуур түвшинд хадгалагдаж байна (Зураг 3.14).

Банкны салбарын нийт зээлд эзлэх хэрэглээний зээлийн хэмжээ буурч тогтворжсон хэдий ч, 2023 оноос эргээд нэмэгдэж байна. Тодруулбал, банкны салбарын нийт зээлд эзлэх хэрэглээний зээлийн хувь 2018 оны эцэст 36.2 хувьд хүрч нэмэгдээд байсан бол 2019 оноос эхлэн буурч, 2021-2022 онд дунджаар 26.6 хувьд хүрч тогтворжсон (Зураг 3.15). Гэсэн хэдий ч, 2024 оны 6 дугаар сарын байдлаар банкны салбарын зээлийн 31.2 хувийг хэрэглээний зээл бүрдүүлж буй бөгөөд үүний 8.9 нэгж хувийг хязгаарлалтгүй хэрэглээний зээл эзэлж байна. 2023 оноос эхлэн иргэдийн цалингийн орлого нэмэгдэж, улмаар ӨОХ-ны хязгаарлалттай зээл олголт өсөхийн зэрэгцээ хязгаарлалтгүй буюу хадгаламж барьцаалсан, тэтгэврийн зээл олголт ихээр нэмэгдлээ.

Өр орлогын харьцааны хязгаарлалтаас гадуурх² хэрэглээний зээлийн өсөлт эрчимжив. Хуульд³ тусгагдсан байсан


тэтгэврийн зээлийн хугацааны хязгаарлалт 2021 оны 7 дугаар сард уг хуулийн шинэчилсэн найруулгаас хасагдсанаас хойш тэтгэврийн зээлийн хэмжээ огцом нэмэгдэж эхэлсэн. Түүнчлэн, цар тахлын үед төрөөс үзүүлсэн бодлогын нөлөөгөөр иргэдийн хадгаламж өсөж, улмаар 2022 оны дунд үеэс хадгаламж барьцаалсан зээлийн хэмжээ ихээр нэмэгдэв.

Зураг 3.14. Дундаж ӨОХ ба олгосон хугацаа



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.15. Банкны салбарын нийт зээлд хэрэглээний зээлийн эзлэх хувь



Эх сурвалж: Монголбанк


Энэ оны эхний хагаст шинээр олгосон хэрэглээний зээл жилийн 31.2 хувиар өссөний 15.2 нэгж хувийг хязгаарлалтгүй зээлүүд бүрдүүлэв. Оны эхний хагаст олгосон хэрэглээний зээлийг авч үзвэл 2017-2021 онуудад дунджаар 3.4 их наяд төгрөгийн зээл шинээр олгож байсан бол сүүлийн 3 жилд эрс

² Тэтгэврийн зээл ба хадгаламж барьцаалсан зээлүүд нь ӨОХ-ны хязгаарлалтад ордоггүй.

³ Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай

нэмэгдэж 10.3 их наяд төгрөгт хүрлээ. Үүнээс 5.3 их наяд төгрөгийн зээл нь хязгаарлалтгүй хэрэглээний зээл байна (Зураг 3.16).


Зураг 3.16. 2024 оны эхний хагаст шинээр олгосон хэрэглээний зээл, бүрэлдэхүүн /их наяд төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

Хязгаарлалтгүй хэрэглээний зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 35.4 хувиар нэмэгдэж 3.0 их наяд төгрөгт хүрчээ. Үүнийг бүрэлдэхүүн хэсгээр авч үзвэл, тэтгэврийн зээл 592.0 тэрбум төгрөгөөр буюу 60.5 хувиар нэмэгдэж 1.6 их наяд төгрөгт, хадгаламж барьцаалсан зээл 181.4 тэрбум төгрөгөөр буюу 15.1 хувиар нэмэгдэж 1.4 их наяд төгрөгт хүрсэн байна (Зураг 3.17).

Зураг 3.17. Хязгаарлалтгүй хэрэглээний зээл




Эх сурвалж: Монголбанк

3.2.3 Банкны салбарын эх үүсвэрийн долларжилт

Эх үүсвэрийн долларжилт буурч, зээлийн долларжилт бага түвшинд хадгалагдаж байна. Банкны салбарын харилцах, хадгаламжийн долларжилт 2024 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.8 нэгж хувиар буурч 22.8 хувьд хүрлээ. Үүнийг бүрэлдэхүүн хэсгээр авч үзвэл, харилцах дансны долларжилт 28.8 хувь байгаа бол хадгаламжийн долларжилт 19.0 хувь байна. 2022 оны ханшийн огцом сулралтын үед эх үүсвэрийн долларжилт 36.6 хувьд хүрч өсөөд байсан бол 2022 оны эцсээс эхлэн экспорт, төлбөрийн тэнцэл сайжирч, ГВУН нэмэгдсэнээр гадаад валютын ханш тогтворжиж, үүнийг дагаад долларжилт эрчимтэй буурлаа. Ингэснээр манай улс долларжилтын үзүүлэлтээрээ ОУВС-гийн судалгааны дагуу дунд түвшин (10-30 хувь) гэсэн ангилалд хэвээр байна. Харин зээлийн долларжилт өнгөрсөн хоёр жилийн хугацаанд

6.0 хувийн орчимд тогтвортой хадгалагдаж байна (Зураг 3.18).

Зураг 3.18. Зээл, хадгаламжийн долларжилт



Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: Бодит долларжилт нь 2019.01.01-ний өдрөөс хойших ханшийн өөрчлөлтийн нөлөөг хасч тооцсон үзүүлэлт болно.


Эх үүсвэрийн долларжилт ийнхүү буурч байгаа нь банкны системийн тайлан тэнцэлдэх валютын төрлийн зөрүүтэй байдал (currency mismatch)-ыг багасгах, ханшийн хэлбэлзэл буурах, цаашлаад мөнгөний бодлого, түүний шилжих механизмын нөлөөг сайжруулах, санхүүгийн системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх зэрэг эерэг нөлөөтэй юм.

Хадгаламжийн долларжилт ийнхүү буурсан нь валютын хадгаламжийн хэмжээ буурч, төгрөгийн хадгаламж нэмэгдсэнтэй холбоотой байна. 2023 оноос эхлэн төгрөгийн гадаад валюттай харьцах ханш алгуур чангарч, ханшийн хүлээлт сайжирснаар төгрөгийн хадгаламжийн хэмжээ нэмэгдсэний зэрэгцээ, валютын хадгаламжийн хэмжээ буурлаа. Улмаар хадгаламжийн долларжилт 2023 оноос эхлэн тасралтгүй буураад байна (Зураг 3.19).

Гадаад валютын хадгаламжийн хэмжээ буурахад гадаад валютын бусад хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өгөөж нөлөөлж байна. Дэлхийн томоохон Төв банкууд бодлогын хүүгээ удаан хугацаанд өндөр хэвээр хадгалж, гадаад валютаарх эрсдэлгүй хөрөнгийн өгөөж өндөр байгаа нь гадаад валютын хадгаламжийн өрсөлдөх чадварыг бууруулж, улмаар гадаад валютын хадгаламжийн хэмжээ буурахад нөлөөлж байна. Тухайлбал, ам.долларын эрсдэлгүй хөрөнгө болох АНУ-ын ЗГ-ын үнэт цаас (жилийн хүү 4.35%-5.38%) Монголын арилжааны банкуудын ам.долларын хадгаламжийн дундаж хүү (2024 оны 6 дугаар сарын байдлаар 3.6%)-нээс илүү өгөөж санал болгож, гадаад валютын хадгаламж эзэмшигчдийн хувьд гадны зах зээлд хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлж байна. Энэ нь цаашид валютын гадагшлах урсгал нэмэгдэх, төгрөгийн ханшийн сулрах дарамтыг өсгөх эрсдэлтэй юм.

Валютын хадгаламжийн харьцангуй өгөөж эрчимтэй буурч, төгрөгийн хадгаламжийнхаас бага түвшинд байна. 2022 оны ханшийн огцом сулралтын үед валютын хадгаламж эзэмшигчийн ханшийн өөрчлөлт болон хадгаламжийн хүүнээс авч буй нийлбэр өгөөж нь төгрөгийн хадгаламжийн хүүнээс харьцангуй өндөр болж байсан бол 2023 оноос эхлэн төгрөгийн ханш чангарах төлөвт шилжсэнээр валютын хадгаламжийн харьцангуй өгөөж хурдацтай буурч, төгрөгийнхөөс бага түвшинд хадгалагдаж байна (Зураг 3.20).

Зураг 3.19. Хадгаламжийн долларжилтын өөрчлөлтийн бүтэц /оны эхнээс өсөн нэмэгдэх/



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3.20. Гадаад валютын болон төгрөгийн жилийн өгөөж



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш алгуур чангарч байгаа нь долларжилт буурахад эерэг нөлөө үзүүлж байна.


Төгрөгийн ам.доллартай харьцах ханш харьцангуй тогтвортой байсан 2020-2021 онд гадаад валютын харилцах, хадгаламжийн хэмжээ алгуур буурч, харин 2022 оны эцэст төгрөгийн ам.доллартай харьцах ханш жилийн 20.9 хувиар суларч, гадаад валютын харилцах, хадгаламжийн хэмжээ энэ хугацаанд жилийн 57.3 хувиар огцом өсөж байв (Зураг 3.21). Харин 2023 оны эхнээс төгрөгийн ханш алгуур чангарч, энэ хугацаанд гадаад валютаарх эх үүсвэрийн хэмжээ мэдэгдэхүйц буурсан байна.

Хувийн байгууллагаас татсан эх үүсвэр хамгийн өндөр долларжилттай байна.

Тодруулбал, хувийн байгууллагын харилцах,

хадгаламжийн хэмжээ 3.7 их наяд төгрөг, долларжилтын хувь 39.9 хувь байна. Энэ нь нийт гадаад валютын харилцах, хадгаламжийн 42.7 хувийг бүрдүүлж байна.

Зураг 3.21. Гадаад валютын харилцах, хадгаламж болон ханш



Эх сурвалж: Монголбанк

3.2.3 Санхүүгийн байгууллагуудын харилцан хамаарал

Санхүүгийн салбарын эрсдэлийг илэрхийлэгч нэг гол үзүүлэлт нь санхүүгийн байгууллагуудын харилцан хамаарал (interconnectedness) юм. Санхүүгийн байгууллагуудын харилцан хамаарал нэмэгдэх нь макро эдийн засгийн болон санхүүгийн шокийн нөлөөг нэмэгдүүлэн, банкуудад ар араасаа хүндрэл бий болох замаар санхүүгийн системийн хямралыг үүсгэх эрсдэлтэй. Ялангуяа системд нөлөө бүхий банк (СНББ)-уудын хувьд хэмжээ болон харилцан хамаарлаасаа шалтгаалан санхүүгийн системд хохирол учруулалгүйгээр зах зээлээс гарах боломжгүй байдаг.

Сүүлийн 1 жилийн хугацаанд банкуудын харилцан хамаарал бага зэрэг нэмэгджээ.

Банкуудын харилцан хамаарлыг банк хоорондын өглөг, авлагын тоон мэдээлэлд үндэслэн тооцоолоход 2023 оны 6 дугаар сард банкны системийн нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 5.6 их наяд төгрөг, үүний 18.9 хувьтай тэнцэхүйц хэмжээний (1.06 их наяд төгрөг)

банк хоорондын өглөг, авлагатай байв. Харин 2024 оны 6 дугаар сард банкуудын өглөг, авлагын хэмжээ 7.2 хувиар өсөж, 1.13 их наяд төгрөгт хүрч нэмэгдлээ. Түүнчлэн, банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээ нэмэгдэж 6.2 их наяд төгрөгт хүрснээр банкууд хоорондын өглөг, авлагын хэмжээ өөрийн хөрөнгийн 18.2 хувьтай тэнцэж байна.

Системд нөлөө бүхий банк (СНББ)-уудын хоорондын өглөг, авлага өсчээ.

СНББ-уудын хувьд бусад банкуудад өгөх өглөгийн хэмжээ 2018 онд өөрийн хөрөнгийн 9.2 хувь, 2023 оны 6 дугаар сард 7.8 хувьтай тэнцэж байсан бол энэ үзүүлэлт 2024 оны 6 дугаар сард 11.1 хувь болж нэмэгджээ. СНББ-уудын жижиг банкуудаас хамаарах хамаарал төдийлөн өөрчлөгдөөгүй, бага байгаа бол СНББ-ууд хоорондын хамаарал нь эрчимтэй нэмэгдсэн байна. Тодруулбал, СНББ-уудын хоорондын өглөг, авлагын хэмжээ 2024 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.5 дахин нэмэгдэж 396.6 тэрбум төгрөгт хүрчээ. Түүнчлэн, 2023

онд СНББ-уудын нийт өглөгийн хэмжээний 42.4 хувийг бусад СНББ-уудад өгөх өглөг бүрдүүлж байсан бол 2024 оны 6 дугаар сарын байдлаар тус үзүүлэлт 65.6 хувь болж нэмэгджээ (Зураг 3.22, 3.23).


Харин активын хэмжээ бага, жижиг банкуудын хувьд бусад банкнаас хамаарах хамаарал тодорхой хэмжээгээр буурсан боловч хамаарлын түвшин өндөр хэвээр байна. Жижиг банкуудын хувьд сүүлийн 1 жилийн хугацаанд бусад банкуудад өгөх өглөгийн хэмжээ 22.0 хувиар буурч, 528.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өөрийн хөрөнгийн 69.9 хувьтай тэнцэж байна. Жижиг банкуудын нийт өглөгийн 65.5 хувийг бусад жижиг банкуудад өгөх өглөг бүрдүүлж байна.

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-уудын банкуудад байршуулсан хөрөнгийн дийлэнхийг харилцах дансны үлдэгдэл, хадгаламж бүрдүүлж байна. 2024 оны


6 дугаар сарын байдлаар банкууд ББСБ-уудаас 40.1 тэрбум төгрөгийн авлагатай байгаагаас 37.0 тэрбум төгрөг нь зээл байна. Харин ББСБ-уудын банканд байршуулсан хөрөнгийн хэмжээ 504.5 тэрбум төгрөг байгаагаас 315.1 тэрбум төгрөгийг нь харилцах дансны үлдэгдэл, 189.4 тэрбум төгрөгийг нь хадгаламж бүрдүүлж байна.

Банк хоорондын өглөг, авлагын хэмжээ жижиг банкуудын хувьд буурсан хэдий ч СНББ-уудын хувьд эрчимтэй нэмэгдэх хандлагатай байгаа нь банкны системд эрсдэл үүсгэж болзошгүй. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын банкны салбар их хэмжээгээр тэлсэн, санхүүгийн үйл ажиллагааны гүнзгийрэл болон нарийн төвөгтэй байдал (complexity) нэмэгдсэнээр банк хоорондын өглөг авлагын хэмжээ нэмэгдэж байна. Иймд зохицуулагч байгууллагын зүгээс санхүүгийн байгууллагуудын харилцан хамаарлын эрсдэлийг тогтмол хянаж байна.

Зураг 3.22. Банк хоорондын хамаарал (2023 оны 6 сарын байдлаар, тэрбум төгрөг)



Зураг 3.23. Банк хоорондын хамаарал (2024 оны 6 сарын байдлаар, тэрбум төгрөг)



Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Зураас өргөн болох тусам хоорондын хамаарал өндөр байгааг илэрхийлнэ. ББСБ-уудын хувьд банкуудад байршуулсан харилцах дансны үлдэгдлийг оруулаагүй болно. Мөн ББСБ-ууд хоорондын өглөг, авлагын мэдээллийг оруулаагүй болно.

ШИГТГЭЭ 5. БАНКУУДЫН ЭРСДЭЛИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА


Монголбанкнаас “Арилжааны банкуудын эрсдэлийн хүлээлтийн судалгаа”-г нийт 12 банкны эрсдэлийн удирдлага эрхэлсэн удирдлагуудаас асуулгын аргаар мэдээлэл цуглуулан, 2024.02.05 - 02.19-ны хооронд 6 дахь жилдээ зохион байгууллаа. Судалгааны үр дүнгээр арилжааны банкууд 2024 оны эрсдэлийн нөхцөл байдал, хүлээлтийг дараах байдлаар үнэлж байна. Үүнд:

- **Банкуудын зээл, хадгаламж, ашигт ажиллагаа:** Банкуудын ашигт ажиллагаа нь 2024 онд өмнөх онтой харьцуулахад бага зэрэг сайжирна гэсэн хүлээлттэй байна. Ашигт ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд 2023 онд том болон дунд банкууд дунджаар 16.9%, харин жижиг банкуудын хувьд 72.3%-иар зээлээ өсгөхөөр төлөвлөжээ. Ингэхдээ дээрх банкууд бүгд иргэдийн болон бизнесийн зээлийн багцуудаа аль алийг нь нэмэгдүүлэхээр тооцоолж байна. Тухайлбал, иргэдийн бусад хэрэглээний зээл⁴, худалдааны салбар, жижиг дунд үйлдвэрлэлд олгох болон ногоон зээлийн багцын хэмжээг өсгөнө гэж хариулжээ. Энэ нь банкууд эдгээр сегментэд илүү ихээр төвлөрч, үйл ажиллагаагаа чиглүүлэх хандлагатай байгааг илтгэж байна. Харин хадгаламжийн хэмжээгээ өмнөх онтой харьцуулахад том банкууд дунджаар 17.5%, дунд банкууд 12.1%, жижиг банкууд 47.5%-иар нэмэгдүүлэх хүлээлттэй байгаа бөгөөд үйл ажиллагааны зардлаа бууруулахдаа автоматжуулалт болон цахимжуулалтыг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.
- **Санхүүгийн зах зээлийн эрсдэлийн хувьд** хүлээлт өмнөх онтой харьцуулахад бага зэрэг сайжирсан нь төгрөгийн ханш болон үл хөдлөх хөрөнгийн үнэ харьцангуй тогтвортой байна гэж таамаглаж буйтай холбоотой юм. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханшийг 2024 онд өмнөх онтой харьцуулахад ойролцоогоор 2.7%-иар суларна, үл хөдлөх хөрөнгийн үнийг дунджаар 2.5%-иар өснө гэж үзжээ.
- **Хөрвөх чадварын эрсдэлийн хувьд** банкууд өмнөх онуудын хүлээлтийн адил мөнгөн хөрөнгийн дутагдалд орох эрсдэл бага байх бөгөөд хөрвөх чадвар буурахгүй гэж үзжээ.
- **Макро эдийн засгийн эрсдэл:** 2024 онд макро эдийн засагт гарах өөрчлөлтүүдийн банкны үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлийн хүлээлт өмнөх онтой харьцуулахад бага зэрэг муудсан байна. Тухайлбал, эдийн засгийн өсөлтийг өмнөх онтой харьцуулахад бага зэрэг буурна гэж таамаглаж байгаа бол жилийн инфляцыг 2023 оны эцэст 8-12% орчимд байна гэж хүлээжээ.
- **Гадаад эрсдэлийн хувьд** банкуудын дундаж индексээр тооцвол 2024 оны хүлээлт 2023 оныхтой харьцуулахад бага зэрэг муудсан хэдий ч 5 банк олон улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал сайжирна гэж хүлээж байна. Эрсдэл нэмэгдэх гол шалтгаан нь олон улсын геополитикийн зөрчил байна гэж банкууд үзэв. Түүнчлэн, олон улсын геополитикийн зөрчил нь гадаад төлбөр тооцоонд хүндрэл учруулах, гадаад эх үүсвэрийн дутагдалд орох болон зээлийн эрсдэл нэмэгдэх зэргээр банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө гэж үзсэн байна.
- **Зээлийн чанарын хувьд** банкуудын 58 хувь нь бага зэрэг сайжирна, 17 хувь нь бага зэрэг муудна, 25 хувь нь өөрчлөлт гарахгүй гэсэн хүлээлттэй байв. Активын чанарыг сайжруулах хамгийн түгээмэл арга нь өмнөх жилүүдийн адил шүүхийн бус журмаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох гэж ихэнх банк үзэж байна. Түүнчлэн, “зээлийн барьцаа хөрөнгийг зах зээлийн бодит үнэ цэнээр тогтооход анхаарч байгаа” гэсэн хариулт удаалж байна. Тухайлбал, чанаргүй активыг шийдвэрлэхэд тулгарч буй гол бэрхшээл нь “шийдвэрлэх хугацаа хэт урт, шат дарааллын хувьд нарийн, түвэгтэй” гэж хариулсан нь 2022, 2023 онуудын судалгааны үр дүнтэй адил хэвээр байгаа бол дараагийн гол бэрхшээл нь “чанаргүй актив болон барьцаа хөрөнгийн худалдан авах борлуулах зах зээлийн орчин сул” гэж дүгнэжээ.

⁴ Цалин, тэтгэвэрийн зээлээс бусад хэрэглээний зээл хамаарна.

- **Ерөнхийд нь өмнөх оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 2024 онд банкны салбарын эрсдэлийн хүлээлт дийлэнх үзүүлэлтийн хувьд сайжирсан байна.** Тухайлбал, банкуудын стратеги, ашигт ажиллагаа, санхүүгийн зах зээлийн эрсдэл, хөрвөх чадвар болон ерөнхий эрсдэлийн хүлээлт сайжирсан үзүүлэлттэй байна. Харин макро эдийн засаг болон гадаад эрсдэлийн хүлээлт бага зэрэг муудсан боловч дундаж эрсдэлтэй гэсэн ангилалд байна.

Зураг 3.24. Банкуудын эрсдэлийн хүлээлтийн нэгдсэн индекс



Эх сурвалж: Монголбанк

Тэмдэглэл: Эрсдэлийн дундаж үнэлгээ

(1-маш өндөр, 2-өндөр, 3-дундаж эрсдэлтэй, 4-бага, 5-маш бага гэсэн утгатай)

3.3 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ


3.3.1 Хөрөнгийн зах зээл

Санхүүгийн зохицуулагч байгууллагаас хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох хүрээнд хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Тодруулбал, үнэт цаасны зах зээлийн голлох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулсны зэрэгцээ ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа нь хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөх, хөрвөх чадвар сайжрах суурь нөхцөлийг бүрдүүллээ.

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2024 оны эхний хагас жилийн байдлаар 11,305.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өссөн бөгөөд энэ нь 2023 оны нэрлэсэн ДНБ-ий 16.0 хувьтай тэнцэж байна (Зураг 3.25). Тайлант хугацаанд нийт арилжаалагдсан үнэт цаасны дүн өмнөх оны мөн үеэс 59.3 хувиар өсөж, 850.7 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 66.4 хувийг компанийн бонд, 21.9 хувийг хувьцаа, 7.2 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 4.5 хувийг хөрөнгө оруулалтын сан тус тус эзэлж байна (Зураг 3.26). “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас тооцдог хамгийн өндөр үнэлгээтэй 20 компанийн зах зээлийн үнэлгээнд суурилдаг ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7,486.0 нэгжээр буюу 20.3 хувиар өсөж 44,385.2 нэгжид хүрэв. Харин MSE А болон MSE В индексийн утгууд харгалзан 17,223.7 нэгж болон 13,387.4 нэгжид хүрч, 6.2 хувь болон 9.9 хувиар тус тус өслөө (Зураг 3.27).

Эдгээр арга хэмжээнүүд нь хөрөнгийн зах зээлийн оролцогчдод төдийгүй шинээр оролцохоор төлөвлөж буй компаниудад томоохон боломж олгох тул хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөх, хөрвөх чадвар сайжрах зэрэг олон эерэг нөлөөтэй байна гэсэн хүлээлттэй байна.


Зураг 3.25. Зах зээлийн үнэлгээ, эхний хагас жилийн эцсийн байдлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Тайлбар: Хөрвөх чадварыг хоёрдогч зах зээлийн хувьцааны арилжааны дүнг зах зээлийн үнэлгээнд хувааж тооцов.

Зураг 3.26. Үнэт цаасны арилжаа, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.27. MSE A, MSE B, ТОП–20 индекс, эхний хагас жилийн байдлаар /хаалтын ханш, сараар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Геополитикийн тогтворгүй байдал өндөр хэвээр байгаа нь хөрөнгийн зах зээлд тодорхой эрсдэл дагуулж болзошгүй байна.


Орос-Украины мөргөлдөөн хурцдах, Улаан тэнгист халдлага үргэлжлэх зэрэг эрсдэлүүд нь дэлхийн зах зээл дээр эрчим хүч, хүнсний үнэ өсөж, манай улсын импортын голлох бараа бүтээгдэхүүний үнийг өсгөх магадлалтай юм. Уг үүсээд буй тодорхой бус байдлаас шалтгаалан дотоод болон гадаад санхүүгийн нөхцөл чангарах, үнэт цаасны арилжааны идэвх, хувьцааны хоёрдогч зах зээлийн хөрвөх чадварыг бууруулж болзошгүй юм.

3.3.2 Даатгалын салбар

Даатгалын компаниудын нийт хөрөнгө 2024 оны эхний хагас жилийн байдлаар 616.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19.0 хувиар өссөн бол нөөц сангийн хэмжээ 290.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19.0 хувиар нэмэгдээд байна (Зураг 3.28).

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 70.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.0 хувиар өссөн бол давхар даатгалын нөхөн төлбөр 8.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.9 дахин нэмэгдээд байна (Зураг 3.29).

Зураг 3.28. Даатгалын салбарын нийт хөрөнгө, эхний хагас жилийн байдлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 222.1 тэрбум төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлсний 99.2 хувь буюу 69.0 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 0.8 хувь буюу 1.7 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компаниуд тус тус төвлөрүүлсэн бөгөөд даатгалын хураамж өмнөх оны мөн үеэс 31.3 хувиар өслөө (Зураг 3.30).

Зураг 3.29. Даатгалын нөхөн төлбөр, эхний хагас жилийн байдлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын зах зээлийн бүтэц


2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 19 даатгалын компани, 62 даатгалын үнэлэгч, 26 даатгалын хохирол үнэлэгч Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байна (Хүснэгт 3.1).

Хүснэгт 3.1. Даатгалын зах зээлийн оролцогчид

№	Даатгалын зах зээлийн оролцогчид	2024.II
1	Даатгалын компанийн тоо	19
	Үүнээс: ердийн даатгалын компани	16
	Үүнээс: урт хугацааны даатгалын компани	2
	Үүнээс: давхар даатгалын компани	1
2	Даатгалын зуучлагч компанийн тоо	62
3	Даатгалын хохирол үнэлэгч компанийн тоо	26
4	Аудитын компанийн тоо	45
5	Аудиторын тоо	147
6	Актуарчийн тоо	40
7	Даатгалын төлөөлөгчийн тоо	2490

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.30. Даатгалын хураамж, эхний хагас жилийн байдлаар /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

3.3.3 Банк бус санхүүгийн байгууллагын салбар

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 549 банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 82.0 хувь нь Улаанбаатар хотод байршдаг. Нийт ББСБ-уудын 88.5 хувь буюу 486 нь тусгай зөвшөөрлийн дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэж байна. Салбарын нийт харилцагчдын тоо давхардсан тоогоор 4.9 сая хүрч өмнөх оны мөн үеэс 25.1 хувиар, зээлдэгчдийн тоо 1.9 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 41.1 хувиар тус тус өсөв (Зураг 3.31).

Зураг 3.31. ББСБ-ын харилцагчид (мянга) ба тоо, эхний хагас жилийн байдлаар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-уудын нийт хөрөнгө болон зээл олголт эрчимтэй тэлж байна. Нийт хөрөнгө 2024 оны 2 дугаар улиралд 5.8 их наяд төгрөгт


хүрч, өмнөх оны мөн үеэс 45.9 хувиар, нийт зээлийн хэмжээ 4.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 47.7 хувиар тус тус өсөөд байна (Зураг 3.32).

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын орлогын хэмжээ 54.0 хувиар буюу 280.7 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 43.7 хувиар буюу 144.7 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 71.9 хувиар буюу 136.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ББСБ-ын нийт зээлийн 90.8 хувийг буюу 4.2 их наяд төгрөгийг хэвийн, 3.0 хувийг буюу 137.9 тэрбум төгрөгийг хугацаа хэтэрсэн, **6.2 хувийг буюу 282.8 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.** Зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 3.5 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өслөө (Зураг 3.33).

ББСБ-уудын бусдаас татан төвлөрүүлж буй хөрөнгийн хэмжээ нэмэгдэж байна. ББСБ-ууд нь ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогтой байсан хэдий ч сүүлийн жилүүдэд бусдаас итгэлцэл, өрийн бичиг, дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр хэлбэрээр, мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар эх үүсвэр татах нь нэмэгдэж байна.


Зураг 3.32. ББСБ-ын нийт хөрөнгө ба зээл, эхний хагас жилийн байдлаар /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тухайлбал, салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 1.8 их наяд төгрөг буюу 45.9 хувиар өссөн бөгөөд энэхүү өсөлтийн 28.0 нэгж хувийг өр төлбөрийн өсөлт, 17.9 нэгж хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Нийт өр төлбөрийн нийт активт эзлэх хувь 44.9 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 2.5 нэгж хувиар нэмэгдэв (Зураг 3.34).


Зураг 3.33. ББСБ-ын зээлийн чанар, жил бүрийн эхний хагасын байдлаар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл өр төлбөрөөс итгэлцлийн үйлчилгээний өглөг 96.9 хувиар, банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 2.0 дахин, бусад эх үүсвэр 47.3 хувиар өссөн бол өөрийн хөрөнгөөс хуримтлагдсан ашиг 49.5 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 16.8 хувиар тус тус өссөн.

Зураг 3.34. ББСБ-ын өр төлбөрийн бүтэц, эхний хагас жилийн байдлаар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-уудын бусдаас татан төвлөрүүлж буй хөрөнгийн хэмжээ нэмэгдэж байгаа нь бусдын хөрөнгийг эрсдэлд оруулах, хууль бус хөрөнгө татан төвлөрүүлэх улмаар салбарын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд эх үүсвэр татан төвлөрүүлсэн ББСБ-уудад тавигдах хяналт, зохицуулалтыг сайжруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

3.3.4 Хадгаламж, зээлийн хоршооны салбар

2024 оны 2 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй Хадгаламж зээлийн хоршоо /ХЗХ/-дын тоо өмнөх онтой харьцуулахад 11 буюу 5.7 хувиар буурч 181-д хүрлээ. Харин ХЗХ-дын гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар өсөж 74,186-д хүрлээ. Тайлант улиралд нийт 181 ХЗХ-ноос 92 ХЗХ нь Улаанбаатар хотод, 89 ХЗХ нь орон нутагт бүртгэлтэй байна. Улсын хэмжээнд ХЗХ-ноос зээл авсан нэг зээлдэгч гишүүн дунджаар 8.1 сая төгрөгийн зээлтэй байна. Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 13.4 сая төгрөг байгаа бол орон нутагт 3.6 сая төгрөг байна.


Тайлант улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар өсөж 327.8 тэрбум төгрөгт, нийт зээлийн хэмжээ 10.4 хувиар өсөж 243.3 тэрбум төгрөгт тус тус хүрлээ. Түүнчлэн цэвэр зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 14.3 хувиар өсөж 246.6 тэрбум төгрөгт, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 4.3 хувиар өсөж 4.9 тэрбум төгрөгт хүрэв (Зураг 3.35-3.36).

Нийт зээлийн үлдэгдлийн 94.2 хувь буюу 229.3 тэрбум төгрөгийг хэвийн, 3.0 хувь буюу 7.2 тэрбум төгрөгийг хугацаа хэтэрсэн, 2.8 хувь буюу 6.8 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Чанаргүй зээлийн ангилал дахь хэвийн бус зээлийн эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 6.6 нэгж хувиар өсөж 33.0 хувь, эргэлзээтэй зээлийн эзлэх хувь 14.1 нэгж хувиар буурч 20.3 хувьд хүрсэн бол муу зээлийн нийт чанаргүй зээлд эзлэх жин 46.7 хувь байна (Зураг 3.37).

ХЗХ-дын хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар өсөж 226.1 тэрбум төгрөг боллоо (Зураг 3.38). Харин хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж сарын хүү 1.3 хувь, зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 2.3 хувь байна (Зураг 3.39).


Нийт олгосон зээлийн 38.0 хувь нь хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаанд, 6.6 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний зориулалтаар, 6.1 хувийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны зориулалтаар олгогдсон. Нийт эргэн төлөгдсөн зээлийн 29.7 хувь нь хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, 7.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний зориулалтаар, 2.0 хувь нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт олгосон зээлээс тус тус бүрдэж байна.

Зураг 3.35. ХЗХ-дын салбарын нийт хөрөнгө ба хөрөнгийн өсөлт /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.36. ХЗХ-дын нийт зээл, чанаргүй зээл /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.37. Чанаргүй зээлийн ангилал, эхний хагас жилийн эцсийн байдлаар

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-дын тоо сүүлийн жилүүдэд тасралтгүй буурч байна. Зохицуулагч байгууллагаас зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 4 улирал дарааллан хангаагүй, өөрийн хөрөнгөгүй болсон, хоршоологчдын өмчгүй болж үйл ажиллагаа нь доголдсон ХЗХ-дын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шат дараатай арга хэмжээ авч хүчингүй болгосноор ХЗХ-дын тоо сүүлийн жилүүдэд тасралтгүй буурч байна.

ХЗХ-дын зах зээлийн цаашдын тогтвортой байдлыг хангахын тулд тасралтгүй хөгжиж байгаа зах зээлийн чиг хандлагад тохирсон хадгаламж, зээлийн хоршоог хөгжүүлэх эрх зүйн орчин, зохицуулалтыг бий болгох хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Зураг 3.38. ХЗХ-дын хадгаламж, эхний хагас жилийн эцсийн байдлаар /тэрбум төгрөг/

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.39. Хадгаламж болон зээлийн жигнэсэн дундаж хүү, эхний хагас жилийн байдлаар

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

3.3.5 Виртуал хөрөнгийн зах зээл

Монгол улсын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын хувьд 2024 оны эхний хагас жилийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд нийт 12 хуулийн этгээд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэлтэй байна.

Эдгээр 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн платформ дээр давхардсан тоогоор нийт 883,658 хэрэглэгч бүртгэлтэй байна. Үүнээс 49.3 хувь буюу 435,520 хэрэглэгч бүртгэлээ баталгаажуулсан бол 2.8 хувь буюу 24,736 хэрэглэгч идэвхтэй арилжаанд оролцдог (Зураг 3.40). Түүнчлэн 724 виртуал хөрөнгө бүртгэлтэй байгаагаас 6.3 хувь буюу 45 нь дотоодын харин үлдсэн 93.7 хувь буюу 679 нь гадаадын виртуал хөрөнгө болно (Зураг 3.41).

Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан хийгдсэн дотоодын виртуал хөрөнгийн өдрийн дундаж арилжаа 200.4 сая төгрөг байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар дотоодын виртуал хөрөнгийн арилжааны дүн 36.1 тэрбум төгрөгт, зах зээлийн үнэлгээ 161.5 тэрбум төгрөгт хүрч харгалзан 63.2 болон 38.8 хувиар тус тус буурлаа. Тайлант улирлын байдлаар виртуал хөрөнгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүдийн нийт хөрөнгө

65.9 тэрбум төгрөг, орлого 5.3 тэрбум төгрөг, тайлант үеийн алдагдал 5.8 тэрбум төгрөг байна.

Зураг 3.40. ВХҮҮ-ийн харилцагчдын тоо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Виртуал хөрөнгийн салбараар дамжуулан аливаа төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэл (inherent risk) өндөр байна. Виртуал хөрөнгийн салбарт үүсэж болох олон төрлийн эрсдэлийг тодорхойлж, уг эрсдэлийг бууруулах зорилгоор зохицуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа боловч тухайн салбараар дамжуулан үйлдэх аливаа төрлийн гэмт хэргийн эрсдэл өндөр байна. Тухайлбал, мэдээллийн аюулгүй байдал буюу харилцагчдын хувийн мэдээлэл, арилжааны системийн аюулгүй байдлыг алдах эрсдэл өндөр байна. Түүнчлэн, виртуал хөрөнгийн үйлчилгээний онцлог талыг ашиглан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулах эрсдэл ч бий.

Дэлхийн зах зээлд криптовалютын хэрэглээ нэмэгдэж байна. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар дэлхийн зах зээлд нийт 724 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч 13,217 төрлийн виртуал хөрөнгө арилжаалж байгаа бөгөөд өдрийн арилжааны дундаж хэмжээ 172.0 орчим тэрбум доллар байна.

АНУ-ын Үнэт цаас, биржийн хорооноос 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Биткойн спот (ETF⁵), 2024 оны 7 дугаар сарын 22-ны өдөр Этэриум (ETF) зөвшөөрлийг олгож, сертификат олгосон нь олон улсад 2024 онд криптовалютын хэрэглээ нэмэгдэх шалтгаан болж, салбарын өсөлт 2023 онтой харьцуулахад нэмэгдсэн байдалтай байна. Улмаар криптовалютад хөрөнгө оруулах хүмүүсийн тоо болон түүнийг төлбөр болгон ашиглах компаниудын тоо нэмэгдэх төлөвтэй байна. Бизнесүүд үйл ажиллагаагаа оновчтой болгож, зардлаа бууруулахыг эрмэлзэж байгаа тул криптовалютын үндэс болсон блокчейн технологийг илүү ашиглах төлөвтэй байна.

Зураг 3.41. Арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн төрөл



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

⁵ Exchange Traded Fund

3.4 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

3.4.1 ББСБ-ын хэрэглээний зээлийн өсөлт, түүнээс үүдсэн эрсдэл, эмзэг байдал


ББСБ-ын олгох иргэдийн хэрэглээний зээлийн хэмжээ сүүлийн жилүүдэд хурдацтай нэмэгдэж байна. 2024 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар ББСБ-ын хэрэглээний зээлийн үлдэгдэл 2.5 их наяд төгрөгт хүрч, жилийн 54.9 хувиар нэмэгджээ (Зураг 3.42). Үүнд нийлүүлэлт талаас ББСБ-уудын санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдсэн болон цахим зээлийн үйл ажиллагаа эрчимжсэн бол зээлийн эрэлт талаас эдийн засгийн идэвхжил, иргэдийн цалин орлого өссөнтэй холбоотойгоор зээлийн хэмжээ нэмэгджээ.

Санхүүжилтийн эх үүсвэр талаас хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өсөхийн зэрэгцээ өр төлбөрийн хэмжээ ихээхэн нэмэгджээ. Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос 2018-2021 оны хооронд авч хэрэгжүүлсэн ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлсэн бодлогын арга хэмжээний нөлөөгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ бодлого хэрэгжүүлэхийн өмнөх үеэс 2.3 дахин өсөж, тайлант хугацаанд 1.7 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүнээс гадна ББСБ-уудын өр, төлбөрийн хэмжээ 2018 оны эцэстэй харьцуулахад 8.4 дахин, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 74.7 хувиар нэмэгдэж 2.6 их наяд төгрөгт хүрчээ. Өр төлбөрийн өсөлтийг бүрэлдэхүүнээр авч үзвэл итгэлцлийн үйлчилгээний өглөгийн өсөлт 29.5 нэгж хувийг, ББСБ-аас гаргасан өрийн бичгийн өсөлт 13.6 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна (Зураг 3.43).

ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээний өглөг хурдацтай нэмэгдэж байна. Тодруулбал, итгэлцлийн үйлчилгээний өглөг 2024 оны 6 дугаар сарын эцэст жилийн 96.9 хувиар нэмэгдэж 884.8 тэрбум төгрөгт


хүрэв. Үүний 70.8 хувийг иргэдээс татан төвлөрүүлжээ.

Зураг 3.42. ББСБ-ын хэрэглээний зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.43. ББСБ-ын өр төлбөрийн жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Итгэлцлийн үйлчилгээ нь банкны хадгаламжтай ижил төрлийн шинж чанартай, харьцангуй өндөр өгөөжтэй бүтээгдэхүүн юм. Гэвч банкны салбартай харьцуулахад банкны бус санхүүгийн салбарын хяналт зохицуулалт сул, итгэлцлийн үйлчилгээ нь хадгаламжийн даатгалд албан журмаар хамрагддаггүй зэргээс шалтгаалан эдийн засаг, санхүүгийн

зах зээлд хямрал тохиоход чанаргүй зээлийн хэмжээ эрс нэмэгдэх, цаашлаад иргэдээс татан төвлөрүүлсэн итгэлцлийн үйлчилгээний өглөгийг барагдуулахад хүндрэл үүсэх эрсдэлтэй юм.

ББСБ-уудаас олгож буй хязгаарлалт тогтоогоогүй хэрэглээний зээлийн өсөлт өндөр байна. СЗХ-ноос 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн финтек зээлүүдэд өр, орлогын харьцааны хязгаарлалт 70 хувиар тогтоохоор шийдвэрлэсэн. Гэсэн хэдий ч, хязгаарлалтгүй хэсэг болох уламжлалт /финтекийн бус/ зээлийн бүтээгдэхүүн нь нийт хэрэглээний зээлийн өсөлтөд багагүй хувийг бүрдүүлсээр байна Тодруулбал, 2024 оны 2 дугаар улирлын эцэст ББСБ-уудын хэрэглээний зээлийн үлдэгдлийн 60.7 хувийг буюу 1.5 их наяд төгрөгийг уламжлалт зээлүүд бүрдүүлж байна (Зураг 3.44, 3.45).


Иймд тус хязгаарлалтын арга хэмжээг банкнаас бусад санхүүгийн байгууллагаас олгох бүх төрлийн хэрэглээний зээлд давхар мөрдүүлэх нь санхүүгийн салбарт хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтуудын харилцан уялдааг сайжруулж, санхүүгийн системд эрсдэл нэг салбараас нөгөө салбарт шилжин бодлогын үр нөлөөг сулруулахгүй байх боломжтой.

Зураг 3.44. ББСБ-ын хэрэглээний зээлд эзлэх уламжлалт зээлийн хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 3.45. ББСБ-ын хэрэглээний зээлийн жилийн өсөлтийн хувь, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


ШИГТГЭЭ 6. ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ӨГӨГДӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Монголбанкны Зээлийн мэдээллийн сан (ЗМС)-д 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар нийт 1.45 сая иргэний 24.4 их наяд төгрөгийн үлдэгдэл бүхий зээлийн⁶ мэдээлэл бүртгэлтэй байна. Олгосон байгууллагаар авч үзвэл 1.1 сая зээлдэгчийн 20.5 их наяд төгрөгийн зээл банканд, 570 мянган зээлдэгчийн 3.3 их наяд төгрөгийн зээл ББСБ-д хамаарч байна (Хүснэгт 3.2). Нэг иргэн дунджаар 2.7 зээлтэй, нийт зээлийн үлдэгдэл нь дунджаар 16.8 сая төгрөг байна. Иргэд банкнаас дунджаар 26.4 сая төгрөгийн зээл шинээр авч байгаа бол ББСБ болон ХЗХ-ноос дунджаар тус бүр 7.5 сая төгрөгийн зээл авдаг байна (Зураг 3.46).

Хүснэгт 3.2. ЗМС-д бүртгэлтэй үлдэгдэл бүхий зээл

Олгосон байгууллага	Үлдэгдэл /тэрбум ₮/	Зээлийн тоо / мянга/	Зээлдэгчийн тоо /мянга/
Банк	20,480	2,033	1,087
ББСБ	3,282	1,305	570
ХЗХ	62	13	11
Лизинг	291	120	108
Бусад	280	387	313
Нийт	24,394	3,858	1,449

Зураг 3.46. Зээлийн үлдэгдэл болон олгосон дүн, олгосон байгууллагын төрлөөр



Эх сурвалж: Зээлийн мэдээллийн сан

Эх сурвалж: Зээлийн мэдээллийн сан

Банкнаас иргэдэд олгосон, хэвийнээс бусад⁷ ангилалтай зээлийн хувь бусад байгууллагатай харьцуулахад бага байна. ЗМС-д хэвийнээс бусад ангилалд (цаашид ангилалтай зээл гэх) бүртгэлтэй нийт 409.2 мянган зээлдэгч байгаагаас 318.9 мянган зээлдэгч зээлийн үлдэгдэлтэй, нийт ангилалтай зээлийн үлдэгдэл 1.3 их наяд төгрөг байна. Үүнээс банканд хамаарах нь 713.8 тэрбум төгрөг буюу банкны салбарын нийт иргэдийн зээлийн үлдэгдлийн 3.5%-ийг бүрдүүлж байгаа бол ББСБ-ын ангилалтай зээлийн үлдэгдэл 381.8 тэрбум төгрөг буюу ББСБ-ын нийт иргэдийн зээлийн үлдэгдлийн 11.6%-тай тэнцэж байна (Хүснэгт 3.3 болон Зураг 3.47).

Хүснэгт 3.3. ЗМС-д хэвийнээс бусад ангилалд бүртгэлтэй зээл

	Олгосон байгууллага	Үлдэгдэл /тэрбум ₮/	Зээлийн тоо /мянга/		Зээлдэгчийн тоо /мянга/		Ангилалтай зээлийн %
			Үлдэгдэлтэй	Үлдэгдэлгүй	Үлдэгдэлтэй	Үлдэгдэлгүй	
1	Банк	714	76	120	63	87	3.5%
2	ББСБ	382	230	52	109	39	11.6%
3	ХЗХ	10	1.3	1.4	1.3	1.3	16.4%
4	Лизинг	42	18	0.3	17	0.2	14.5%
5	Бусад ⁸	124	281	27	216	21	44.4%
	Нийт	1272	607	200	319	137	5.2%

Эх сурвалж: Зээлийн мэдээллийн сан

⁶ Зээл болон түүнтэй адилтгах үйлчилгээ


⁷ Анхаарал хандуулах болон чанаргүй зээл хамаарна.

⁸ Бусад гэдэгт үүрэн телефон, интернетийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, төрийн сан, дампуурсан банкууд болон даатгалын байгууллагууд багтаж байна.

Зураг 3.47. Ангилалтай зээлийн үлдэгдэл, олгосон байгууллагын төрлөөр



Зураг 3.48. Хэвийнээс бусад ангилалд бүртгэгдсэн нийт зээлдэгчийн тоо




Эх сурвалж: Зээлийн мэдээллийн сан

Тэмдэглэл: *-Үүрэн телефоны 4 оператор, ДДЭШ болон Кевико компаниудын зээлийг бүртгэсэн.

Иргэд гар утас, интернетийн төлбөрөө төлөөгөөгүйгээс үүдэн ЗМС-д ангилалтай зээлдэгчээр бүртгэгдэх хандлага өндөр байна. ЗМС-гийн ангилалтай зээлдэгчдийг авч үзвэл үүрэн телефоны операторууд болон ДДЭШ, Кевико зэрэг интернетийн үйлчилгээ үзүүлэгч компаниудад төлбөрөө төлөөгүй 197.4 мянган иргэд байгаа нь нийт ангилалтай зээлдэгчдийн 37.2%-ийг бүрдүүлж байна (Зураг 3.48). Гэсэн хэдий ч, эдгээр нь зээл бус төлбөрийн үүрэг учраас иргэд төлбөрөө төлсөн даруйд ЗМС-гаас тус мэдээлэл устдаг.

ББСБ-уудын зээлдэгчдийн зээл хэвийн бус ангилалд ихээр шилжиж байна. Банк болон ББСБ-уудын хэвийн бус ангилалтай зээл бүхий зээлдэгчдийн тоо нь ЗМС-д ангилалтай бүртгэгдсэн нийт зээлдэгчдийн тус бүр 26.0%-ийг бүрдүүлж байна (Зураг 3.48). ББСБ-ын иргэдийн зээлийн багц банкныхаас 6.2 дахин бага боловч ижил тооны ангилалтай зээлдэгчидтэй байгаа нь тус салбарын зээл хэвийн бус ангилалд ихээр шилжиж байгааг харуулж байна.

Зураг 3.49. Зээлийн тоо, нийт ангилалтай зээлд эзлэх хувь хэмжээ /олгосон зээлийн дүнгийн тодорхой интервалаар/



Эх сурвалж: Зээлийн мэдээллийн сан

Банк бус санхүүгийн байгууллагаас олгосон бага дүнтэй зээл хэвийн бус ангилалд шилжих хандлага өндөр байна. Финтек салбарын өсөлтийн нөлөөгөөр ББСБ-ууд бага дүнтэй хэтэвчний зээлүүд ихээр олгож, уг зээлдэгчдийн зээл хэвийн бус ангилалд орох нь нийтлэг байна.

Тухайлбал, 500 мянган төгрөгөөс доош дүнгээр олгосон банкны 493 мянган зээл, ББСБ-ын 522 мянган зээл байна. Гэвч ББСБ-уудын хувьд эдгээр зээлүүдийн 24.2% нь хэвийнээс бусад ангилалд байна (Зураг 3.49). Бага дүнтэй зээл ихээр гаргаж, ЗМС-д чанаргүйдлийг бүртгэж буй энэ процесс нь эдгээр зээлдэгчдийн дахин зээл авах боломжийг хязгаарлаж, улмаар санхүүгийн хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдөх асуудал дагуулж байна. Банкны хувьд бага дүнтэй зээлийн чанаргүйдлийн хувь харьцангуй бага байгаа бол банкны бус салбарын хувьд зээлийн дүн бага байх тусам чанаргүйдлийн хувь өндөр байна.

3.4.2 Банк болон ББСБ-д давхар зээлтэй иргэдийн зээлд хийсэн шинжилгээ

Банк болон бусад санхүүгийн байгууллагын⁹ давхар зээлтэй иргэдийн зээлийн дүн нэмэгдэж, санхүүгийн системд нийтлэг хамаарлаас үүдэлтэй эрсдэл тулгарч болзошгүй байна. ЗМС-гийн тоон өгөгдөлд үндэслэн тооцоход 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар банк болон бусад санхүүгийн байгууллагаас давхар зээлтэй нийт 392.1 мянган зээлдэгч байна. Эдгээр зээлдэгчдийн банкны салбараас авсан зээлийн үлдэгдэл 7.6 их наяд төгрөг, бусад байгууллагаас авсан зээлийн үлдэгдэл нь 2.3 их наяд төгрөгт хүрчээ (Зураг 3.50)¹⁰.

Зураг 3.50. Банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллагаас олгосон иргэдийн зээл, их наяд төгрөг, 2024 оны 3 сар



Эх сурвалж: Зээлийн мэдээллийн сан


⁹ Үүнд “Зээлийн мэдээллийн тухай” хуулийн 28.2-т заасан иргэн, хуулийн этгээдээс зөвшөөрөл авсан эсэхээс үл хамааран Монголбанкны мэдээллийн санд зээлийн мэдээллийг тогтмол өгөх үүрэгтэй этгээдүүд болох банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, санхүүгийн түрээс / лизинг/-ийн компани, төрийн байгууллага зэргийг хамруулав.

¹⁰ Бусад санхүүгийн байгууллагаас олгосон дүн нь 500 мянган төгрөгөөс доош зээлүүдийг хасч тооцвол давхар зээлтэй иргэдэд хамаарах банкны зээлийн хэмжээ 7.04 их наяд төгрөг, бусад байгууллагын зээлийн хэмжээ 2.26 их наяд төгрөг байна. Харин 300 мянган төгрөгөөс доош зээлүүдийг хасч тооцвол банканд хамаарах нь 7.31 их наяд төгрөг, бусад байгууллагынх 2.3 их наяд төгрөг байна.

Энэ нь банкны хувьд иргэдэд олгосон зээлийнх нь 37.1 хувийг, банкнаас бусад салбарын хувьд иргэдэд олгосон зээлийнх нь 61.6 хувийг тус тус эзэлж байна. Эдгээр давхар зээлтэй иргэдийн банкны салбарт хамаарах 211.2 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийн үлдэгдэл, бусад байгууллагад хамаарах 164.7 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийн үлдэгдэл тус тус байна. Банк болон бусад байгууллагаас давхар зээлтэй иргэдийн хувьд сөрөг шок тулгарч, зээлийн эргэн төлөлтөд нь хүндрэл учрах тохиолдолд банк, санхүүгийн системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Банк болон ББСБ-аас давхар зээлтэй иргэдийн тоо болон зээлийн дүн хурдтай нэмэгджээ. Банк болон ББСБ-аас давхар зээлтэй иргэдийн тоо 350 мянгад хүрсэн нь 2023 оны 5 дугаар сартай харьцуулахад 26.4%-иар нэмэгджээ. Эдгээр иргэдийн банкны зээлийн үлдэгдэл 6.8 их наяд төгрөгт, ББСБ-ын зээлийн үлдэгдэл 2.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны 5 сараас харгалзан 44.2% болон 53.4%-иар эрс нэмэгдсэн дүнтэй байна (Зураг 3.51).

Зураг 3.51. Банк болон ББСБ-аас олгосон иргэдийн зээл, их наяд төгрөг



Эх сурвалж: Зээлийн мэдээллийн сан

Банкнаас бусад санхүүгийн салбараас олгох уламжлалт хэрэглээний зээлд ӨОХ-ны хязгаарлалт мөрдүүлэхгүй¹¹ байгаагаас шалтгаалан банкнаас ӨОХ-ны хязгаарт тулган хэрэглээний зээл авсан иргэд банкнаас бусад санхүүгийн байгууллагаас нэмж зээл авч, өрийн дарамтад орох эрсдэлтэй байна. Зээлийн мэдээллийн сангийн тоон мэдээлэлд үндэслэн тооцоход банк болон ББСБ-ын давхар зээлтэй иргэдийн хувьд дундаж ӨОХ ойролцоогоор 79.8 хувь байгаа эдгээр зээлдэгчдийн хувьд зээлийн төлбөрийн бодит дарамт өндөр байгааг илтгэж байна.

Иймд Монголбанкнаас банкны олгох иргэдийн хэрэглээний зээлд тогтоосон ӨОХ-ны болон хугацааны хязгаарлалтын арга хэмжээг СЗХ-ноос банкнаас бусад бүх санхүүгийн байгууллагуудаас олгох иргэдийн хэрэглээний зээлд давхар мөрдүүлж, зохицуулагч байгууллагуудын бодлогын уялдааг хангах, санхүүгийн эрсдэл нэг салбараас нөгөө салбарт шилжиж бодлогын нөлөөлөл алдагдах эрсдэлийг бууруулах нь чухал байна.

¹¹ Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрээр 2023 оны эхнээс ББСБ-аас олгох финтек зээлийн бүтээгдэхүүний хувьд ӨОХ-ны 70 хувийн дээд хязгаарыг тогтоон мөрдүүлж байна. Гэвч ББСБ-аас олгосон хэрэглээний зээлийн дийлэнх буюу 62.5 хувийг уламжлалт (финтекээс бусад) буюу ӨОХ-ны хязгаарлалтгүй зээл бүрдүүлсэн хэвээр байна.

4. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

4.1 БАНКНЫ САЛБАРТ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

4.1.1 Банкны үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилт

Монголбанк банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор “Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-ийг 2020 оноос эхлэн хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрийн томоохон зорилтуудын нэг болох банкны хяналт, шалгалтын стандартыг сайжруулах ажлын хүрээнд Монголбанкны зүгээс гүйцэтгэл болон эрсдэлд суурилсан хяналт шалгалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэн ажиллаж байна.

Банкны тухай хууль болон “Банкны тогтворжуулалтын сангийн журам”-ын хүрээнд “Банкны тогтворжуулалтын сангийн жилийн хураамжийг тооцох аргачлал”-ыг шинээр батлав. Банкны тухай хуулийн 62, 63 дугаар зүйл болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-155 дугаар тушаалаар баталсан “Банкны тогтворжуулалтын сангийн журам”-ын дагуу 2022 оноос “Банкны тогтворжуулалтын сан”-гийн хөрөнгө Монголбанканд бүрдүүлж эхэлсэн. Тус санг бүрдүүлснээр банкны системд нөлөө бүхий банк (БСНББ)-нд бүтцийн өөрчлөлт хийхэд шаардагдах санхүүжилтийг бий болгох чухал ач холбогдолтой юм. Банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн хууль ёсны эрхийг хамгаалах үүднээс БСНББ-уудаас тогтворжуулалтын санд төлөх жилийн хураамжийн хэмжээг тогтоохын тулд Олон улсын валютын сангаас

өгсөн зөвлөмж, Европын банкны удирдлагаас гаргасан зохицуулалт болон БСНББ-уудын саналын дагуу сангийн жилийн хураамжийг тооцох зохистой аргачлалтай байх шаардлага тулгарсан. Иймээс тус санд төвлөрүүлэх жилийн хураамжийг тогтоох аргачлалыг илүү боловсронгуй болгон, эрсдэлийн түвшнээс хамаарч БСНББ тус бүр ялгаатай байх нэмэлт хураамжийн хэмжээг тодорхой болгож, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн А-184 дүгээр тушаалаар “Банкны тогтворжуулалтын сангийн жилийн хураамжийг тооцох аргачлал”-ыг баталсан. БСНББ-уудаас 2024 онд тус санд төвлөрүүлэх 15.6 тэрбум төгрөгийн жилийн хураамжийг шинэ аргачлалын дагуу тооцоод байна.

Банкны активыг ангилал дээшлүүлэх нөхцөл шаардлагыг илүү уян хатан болгож, олон улсын жишигт нийцүүлэх ажлыг эхлүүлэв. Монголбанкны Ерөнхийлөгч болон Сангийн сайдын 2019 оны А-155/134 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын активын ангилал дээшлүүлэх шаардлагад Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн А-218 дугаар тушаалаар түр хугацаанд өөрчлөлт орууллаа.

Уг түр зохицуулалтаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 2.9.1.5-д заасан ангилал дээшлүүлэх шаардлагыг банкны хамгийн том 40 зээлдэгч болон 40 том холбогдох этгээдэд олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох активт мөрдөх бөгөөд зохицуулалт

нь журмын шинэчилсэн найруулга батлагдах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Харин бусад зээлүүдийн хувьд уг журмын 2.9.1.1-2.9.1.4-т заасан шаардлагыг хангасан тохиолдолд банк өөрийн эрсдэлийн удирдлагын хүрээнд ангилал дээшлүүлэх боломж олголоо.

Банкнаас жижиг, дунд бизнест олгосон зээл, иргэдэд олгосон зээлийг ангилах, ангилал дээшлүүлэх нөхцөлийг уян хатан болголоо. Банкнаас жижиг, дунд бизнест олгосон зээл, иргэдэд олгосон зээлийг ангилах, ангилал дээшлүүлэх нөхцөлийг уян хатан болгох ажлыг эхлүүлж Монголбанкны Ерөнхийлөгчийн А-216 дугаар тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д өөрчлөлт оруулж, банкнаас жижиг, дунд бизнес эрхлэгчид болон иргэдэд олгосон зээлийн ангиллыг дээшлүүлэхдээ Монголбанкнаас тухай бүр зөвшөөрөл авдаг байсныг өөрчилж, банк хязгаарлалттай эрхийн хүрээнд дотооддоо дээшлүүлэх боломжийг банкуудад олгож, активын ангиллыг уян хатан болголоо.

Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн хүрээнд “Банкны барьцаа хөрөнгийн үнэлгээний журам”-ыг шинээр баталлаа. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь барьцааны зориулалттай үнэлгээний журам, аргачлалыг Монголбанк, эсхүл Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална” гэж заасны дагуу “Банкны барьцаа хөрөнгийн үнэлгээний журам”-ыг боловсруулж, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн А/61, А/65 тоот хамтарсан тушаалаар баталсан. Уг журмын зорилго нь банкуудыг барьцаа хөрөнгийн үнэлгээний үйл

ажиллагаандаа баримтлах нэгдсэн зарчим, шаардлагаар хангах, мөн Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад нийцүүлэн банкууд өөрсдийн журам, бодлогын баримт бичгийг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино.

“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д “Нийслэлийн үнэт цаас”-тай холбоотой нэмэлт орууллаа. Нийслэл Улаанбаатар хот бонд гаргасантай холбоотойгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-138 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д “Нийслэлийн үнэт цаас”-тай холбоотой түргэн борлогдох хөрөнгөд тооцох, эрсдэлээр жигнэх хувь тогтоох, бондын эргэн төлөгдөх нөхцлийг баталгаатай болгох үүднээс зээлээс бусад чанаргүй активын эрсдэлээр жигнэх хувь тогтоох зэрэг зохицуулалтуудыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2024 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А-152 дугаар тушаалаар нэмж орууллаа. Үүнд:

- “Нийслэлийн бонд”-ыг журмын 3.4-т заасан түргэн борлогдох хөрөнгөд нэмж оруулах.
- Журмын 1 дүгээр хавсралтад “Нийслэлийн бонд”-ыг нэмж, эрсдэлээр жигнэх хувийг 20.0 хувиар тогтоох.
- Журмын 1 дүгээр хавсралтад “Зээлээс бусад чанаргүй актив” гэх ойлголтыг нэмж эрсдэлээр жигнэх хувийг 150.0 хувиар тогтоох зэрэг болно.

Журмын нэмэлтийг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т заасны дагуу 2024 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж байна.

Банкуудын хувьцаа эзэмшлийн төвлөрлийг 20 хувь хүртэл бууруулах хуулийн хугацааг сунгалаа. Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт “Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан банкны хувьцаа эзэмшигчийн төвлөрлийн хязгаарлалтыг банкууд Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хангах ёстой байв.

Санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад банкны салбарын хувь эзэмшлийг бууруулах, банкны засаглалыг сайжруулах нь нэн чухал хэдий ч дотоодын хөрөнгийн зах зээлийн багтаамж, олон улсын эдийн засаг, геополитикийн нөхцөл байдал зэрэг гадаад, дотоодын олон хүчин зүйлсээс шалтгаалан хуулийн 36.1 дэх заалтын хэрэгжилт хугацаандаа бүрэн хангагдаагүй. Иймд банкуудад хувь эзэмшлийн төвлөрлөө бууруулахад шаардлагатай цаг хугацааг олгох зорилгоор Монголбанкнаас уг хуулийн заалтыг хэрэгжүүлэх хугацааг 3 жилээр сунгахаар хуулийн төслийг боловсруулан, УИХ-аар хэлэлцүүлэхээр ажилласан. 2024 оны УИХ-ын хаврын чуулганы хуралдаанаар Банкны тухай хуулийн 36.1-д заасан банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг 20 хувь

хүртэл бууруулах шаардлагыг биелүүлэх хуулийг хугацааг 2026 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл сунгахаар батлав.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Кастодианы үйл ажиллагааны журам”-ыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батлав. Улсын Их Хурлаас 2013 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг баталснаар хөрөнгийн зах зээлд кастодианы үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд тус хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 85/А-106 дугаар хамтарсан тушаалаар “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ыг батлан мөрдүүлж ирсэн. Гэвч Үнэт цаасны зах зээлийн тухай, Захиргааны ерөнхий хууль, Зөвшөөрлийн тухай хууль зэрэг хуулиудын эрх зүйн шинэчлэлтийн дагуу хуульд нийцүүлэх хэрэгцээ гарснаар дээрх журмыг “Кастодианы үйл ажиллагааны журам” болгон шинэчлэн найруулж Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А-169/283 тоот хамтарсан тушаалаар батлуулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2024 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 6911 дугаарт бүртгүүлээ.

4.1.2 Макро зохистой бодлогын арга хэмжээнүүд


Монголбанк нь санхүүгийн системийн мөчлөгийн болон бүтцийн эрсдэлүүдийг тогтмол хянаж, мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдан бодит эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор 2019 оноос эхлэн макро зохистой бодлогыг

мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж байна.

Банкнаас олгох хэрэглээний зээлд өр, орлогын харьцаа болон хугацааны хязгаарлалт тогтоон мөрдүүлж байна. Монголбанкнаас иргэдийн хэрэглээний зээлийн өсөлтийг зохистой түвшинд хадгалах,

өрхийн өрийн дарамтыг бууруулах болон банкны системд эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор банкнаас олгох хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцаа (ӨОХ) болон хугацааны хязгаарлалт тогтоон 2019 оноос хойш мөрдүүлж байна. Уг бодлогын арга хэмжээний нөлөөгөөр 2018 оны эцэст 36.2 хувьд хүрээд байсан банкны салбарын нийт зээлд эзлэх хэрэглээний зээлийн хувь хэмжээ 2019 оноос эхлэн эрчимтэй буурч, 2021-2022 онд дунджаар 26.6 хувьд хүрч тогтворжив. Мөн шинээр олгосон хэрэглээний зээлийн хугацаа богино болсон ба хэрэглээний зээлтэй иргэдийн өр, орлогын харьцаа буурч хязгаарлалтаас доогуур түвшинд хадгалагдаж байна. Тодруулбал, 2024 оны 6 сарын байдлаар ӨОХ-ны хязгаарлалт бүхий хэрэглээний зээлийн үлдэгдлийн дундаж ӨОХ нь 50.4 хувь, дундаж хугацаа нь 28 сар байна (Зураг 4.1).

Зураг 4.1. Банкны хэрэглээний зээлийн дундаж ӨОХ ба олгосон хугацаа



Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлах, санхүүгийн системийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор шинээр олгох болон нөхцөл өөрчлөх хэрэглээний зээлийн ӨОХ-ны хязгаарлалтыг чангаруулав. 2023 оноос эхлэн нэрлэсэн цалин, тэтгэвэр, орлогын өсөлтийг дагаад хэрэглээний зээлийн өсөлт эрчимжиж байгаа нь санхүүгийн

салбарт эрсдэл хуримтлагдахад хүргэж байна. Тодруулбал, ӨОХ-ны хязгаарлалттай хэрэглээний зээлийн үлдэгдэл 2024 оны 6 сарын байдлаар 7.4 их наяд төгрөгт хүрч, жилийн 39.4 хувиар өсжээ. Ингэснээр банкны салбарын нийт зээлийн үлдэгдлийн багцын 22.2 хувийг ӨОХ-ны хязгаарлалт бүхий хэрэглээний зээл, 31.3 хувийг нийт хэрэглээний зээл бүрдүүлж байна. Түүнчлэн, банк болон ББСБ-аас давхар зээлтэй иргэдийн тоо хэмжээ, зээлийн дүн огцом нэмэгдэж, санхүүгийн салбарт нийтлэг хамаарлаас үүдэлтэй эрсдэл бодитоор учирч байна. Иймд Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр банкны хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлах, эдийн засгийн сөрөг шокийн үед банкны салбарт үүсэх алдагдлыг бууруулах зорилгоор банкнаас иргэдэд шинээр олгох болон нөхцөл өөрчилсөн хэрэглээний зээлийн хувьд ӨОХ-ны дээд хязгаарыг 60 хувиас 55 хувь болгон бууруулж, 2024 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс мөрдөж эхлэв.

Банкуудын тэтгэврийн зээлийн эрсдэлийн жинг нэмэгдүүлэх шийдвэр гаргалаа.

Банкуудын тэтгэврийн зээлийн хэт өсөлт, өрхийн өрийн дарамт, эрсдэлийг харгалзан үзээд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн тушаалаар үлдэх хугацаа нь 6 сараас дээш, зээлийн сарын төлбөр төлсний дараах үлдэгдэл тэтгэврийн орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага байх тэтгэврийн зээлийн эрсдэлээр жигнэх хувийг 2023 оныг дуустал хугацаанд 150 хувь болгон нэмэгдүүлэв. Улмаар Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2023 оны 4 дүгээр улирлын ээлжит хурлаар дээрх зохицуулалтын хамрах хүрээг өргөтгөж “6 сараас дээш хугацаагаар олгосон, эсхүл зээлийн сарын төлбөр төлсний дараах үлдэгдэл тэтгэврийн орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага байх тэтгэврийн зээл”-ийн хувьд 2024 оны 1-р

сарын 1-ний өдрөөс эхлэн хугацаагүйгээр мөрдөх шийдвэр гаргаж, банкууд үйл ажиллагаандаа мөрдүүлж байна.

Малчны зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учирч болзошгүй болсонтой холбоотойгоор хэрэглээний зээлийн зохицуулалтад өөрчлөлт оруулав. 2024 он гарсаар орон нутагт өвөлжилт, хаваржилт хүндэрч, малын зүй бус хорогдлын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор хэрэглээний зээлийн том бүрдэл хэсэг болох малчны зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учирч болзошгүй болов. Тухайлбал, банкны салбар дахь малчны зээлийн үлдэгдэл 2024 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар 1.3 их наяд төгрөг буюу хэрэглээний зээлийн үлдэгдлийн 14.6 хувийг бүрдүүлж байсан. Үүнтэй холбогдуулан Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 1 дүгээр улирлын ээлжит хурлаар малчны эргэн төлөлт нь доголдсон зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах боломжийг банкуудад олгох шийдвэрийг гаргалаа. Тодруулбал, 2024 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө олгосон, эргэн төлөлт нь доголдсон малчны зээлийн хувьд үлдэгдэл хугацааг 12 сар хүртэлх хугацаагаар, зээлийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр, нэг удаа сунгахыг банкуудад зөвшөөрөв. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхдээ зээлийн ангиллыг хэвээр үлдээх, холбогдох зээлүүдийн хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй өр, орлогын харьцааны болон хугацааны хязгаарлалтыг

арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд түр түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Банкуудын гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулав.

Олон улсад эрсдэлгүй хүүгийн түвшин өндөр хэвээр хадгалагдаж, гадаад валютын заавал байлгах нөөцийн шаардлага өндөр байгаа нь банкуудын эх үүсвэрийн зардлыг өсгөж байгаа тул Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 2 дугаар улирлын ээлжит хурлаар банкны гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 3 хувиар бууруулж, 15 хувьд хүргэх шийдвэрийг гаргалаа.


Бага дүнтэй банкны кредит картын зээл, тодорхой нөхцөл шаардлага хангаж шинээр нэвтрүүлэх боловсролын зээл зэрэг зээлийн бүтээгдэхүүнд ӨОХ-ны хязгаарлалт мөрдүүлэхгүй байхаар шийдвэрлэв.

Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 2 дугаар улирлын ээлжит хурлаар нөөцийн үр дүнтэй хуваарилалт, санхүүгийн зах зээлийн хүртээмж, санхүүгийн бүтээгдэхүүний хөгжлийг дэмжих зорилгоор (1) банкнаас шинээр олгох амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага дүнтэй кредит картын зээлд ӨОХ-ны хязгаарлалт мөрдүүлэхгүй байх, (2) тодорхой нөхцөлүүдийг хангасан дээд боловсролын сургалтын төлбөрийн зээлд ӨОХ-ны болон хугацааны хязгаарлалтыг мөрдүүлэхгүй байх шийдвэрийг тус тус гаргалаа.

ШИГТГЭЭ 7. САНХҮҮГИЙН МӨЧЛӨГ

Монгол Улсын санхүүгийн мөчлөгийн зөрүү эерэг утгатай байгаа боловч төдийлөн өндөр биш байгаа нь санхүүгийн салбарт мөчлөгийн эрсдэл харьцангуй бага байгааг илтгэж байна. Эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг зохистой түвшинд хангах, бизнес, санхүүгийн мөчлөгийн далайцыг бууруулах нь жижиг, нээлттэй эдийн засагтай, гадаад шоконд өртөмтгий манай улсын хувьд томоохон сорилт болдог. Сүүлийн жилүүдэд цар тахал, геополитикийн асуудлуудаас үүдэлтэй гадаад орчны тогтворгүй байдал бий болж, 2021 оны дунд үеэс эхлэн санхүүгийн мөчлөгийн уналтын үе тохиосон бол 2023 оноос эхлэн эдийн засгийн өсөлт сэргэсний зэрэгцээ зээл олголт нэмэгдсэнээр манай улсын санхүүгийн мөчлөг халалтын үед шилжиж, 2024 онд тэнцвэрт түвшнээс бага зэрэг даваад байна (Зураг 4.2). Санхүүгийн мөчлөгийн далайц өмнө тохиож байсан хямралын үеүдтэй харьцуулахад буурч байгаа нь санхүүгийн салбарт авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнг харуулж байна. Ийнхүү мөчлөгийн далайц буурах нь санхүүгийн тогтвортой байдал болон урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмжих, бизнес эрхлэгчид болон эдийн засгийн бусад агентуудад учрах эрсдэлийг багасгахад чухал ач холбогдолтой.

Зураг 4.2. Бизнесийн болон санхүүгийн мөчлөг



Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн мөчлөгийг бүрэлдэхүүн хэсгүүдээр харвал:

- Зээл/ДНБ-ийн харьцаа: 2024 оны эхний хагас жилд банкны салбараас олгосон зээлийн хэмжээ нэрлэсэн ДНБ-ийн 74.6 хувьтай тэнцэж байна. Тус үзүүлэлт 2023 онд 59.3 хувь байв.
- Бодит зээлийн өсөлт: 2024 оны эхний хагаст банкнаас шинээр олгосон зээл жилийн 42.4 хувиар өслөө.
- Орон сууцны үнэ /бодит/: Барилгын өртгийн индекс буурснаас шалтгаалан орон сууцны үнэ сүүлийн 8 улирлын турш тогтвортой хадгалагдаж байна. Ипотекийн зээл олголт цаашид нэмэгдэх төлөвтэй тул орон сууцны үнэ цаашид өсөх эрсдэлтэй.

Сүүлийн 2 жилд зээл олголт эрчимтэй нэмэгдэж байгаа нь эдийн засгийн идэвхжил, иргэдийн хэрэглээ, ААН-үүдийн үйл ажиллагааг дэмжих эерэг нөлөөтэй боловч нийт нийлүүлэлтийн тэлэх боломж хязгаарлагдмал үед зээл олголт хэт өссөнөөр санхүүгийн системд мөчлөгийн эрсдэл хуримтлагдах сөрөг үр дагавартай. Иймд цаашид зээлийн өсөлтийг дотоод эдийн засгийн нөхцөл байдал, макро орчинтой уялдуулан тогтвортой хадгалах шаардлагатай юм.

4.2 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРТ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос 2024 оны эхний хагас жилийн байдлаар Монгол улсын хөрөнгийн зах зээл, даатгалын салбар, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, виртуал хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлд голлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

4.2.1 Хөрөнгийн зах зээл

- ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд нээлттэй компани болохын давуу тал, хөрөнгийн зах зээлд үзүүлэх үр нөлөө, хөрөнгийн зах зээлийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх нэг цэгийн үйлчилгээг зохион байгуулав.
- Санхүүгийн зохицуулах хороо гадаад хамтын ажиллагааны хүрээнд Бүгд Найрамдах Киргиз Улсын Үндэсний банк, Унгар Улсын Төв банктай финтек компаниуд, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг бодлогоор дэмжих, бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг хөгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, хил дамнасан санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл солилцох, газар дээрх хяналт шалгалт хийх, мөн хүний нөөц, байгууллагыг чадавхжуулах чиглэлд хамтран ажиллахаар харилцан ойлголцлын санамж бичиг 2024 оны 2 дугаар сарын 28-ны өдөр, 3 дугаар сарын 7-ны өдөр тус тус байгууллаа.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хуулиудад нэмэлт

өөрчлөлт орсонтой холбоотойгоор “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”, “Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”, “Кастодианы үйл ажиллагааны журам”-д тус тус нэмэлт өөрчлөлт оруулахаар олон нийтээс санал авч, журмын хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан.

4.2.2 Даатгалын салбар

- Даатгалын багц хууль буюу Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлал шинэчлэн батлагдсан бөгөөд хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах, Монгол Улсын Их Хуралд өргөн барих чиглэлээр Сангийн яамтай хамтран ажиллаж байна.
- Даатгагчийн төлбөрийн чадварын тооцооллыг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн сайжруулж, даатгагчийн эрсдэлийг илүү бодитой, нарийвчилсан, өөрт тохирсон аргаар тооцоолох боломжийг олгох зорилгоор эрсдэлд суурилсан аргачлал руу шилжүүлэх зохицуулалтыг тусгасан “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ыг Хорооны 2023.11.08-ны өдрийн 559 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан.
- Ипотекийн даатгалын үйл ажиллагааны зохицуулалтын орчныг сайжруулах зорилгоор “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр ажиллаж, олон нийтээс санал авч байна.

4.2.3 Банк бус санхүүгийн салбар

- Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн хүрээнд бусдын хөрөнгийг удирдаж буй ББСБ-уудын эрсдэл даах чадвар, санхүү, төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 434 дүгээр тогтоолоор “Итгэлцлийн үйлчилгээний журам”-ыг, 2023 оны 136 дугаар тогтоолоор “Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ үе шаттай нэмэгдүүлэх хуваарь”-ыг тус тус баталсан. Энэхүү зохицуулалтын хүрээнд итгэлцлийн үйлчилгээ эрхлэхийг хүссэн ББСБ нь 5.0 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байх, чанаргүй зээлийн багц нь салбарын дунджаас бага байх, 8 улирал дараалан ашигтай ажилласан байх зэрэг үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлж, оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулсан.
- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан “Үндэсний тогтвортой санхүүгийн замын зураг”-ын авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 2030 он гэхэд ногоон зээлийн хэмжээг банкны салбарт 10 хувь, банк бус санхүүгийн салбарт 5 хувь хүргэх зорилтыг дэвшүүлсэн. Түүнчлэн, салбарын оролцогчдыг нийгмийн хариуцлагын хүрээнд гаргах ногоон зээлийг бодлогоор дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нэгдсэн бодлогын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 794 дүгээр тогтоолоор “Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохистой

харьцаа тогтоох тухай” тогтоолыг баталж, тодорхой нөхцөл шаардлага хангасан ББСБ-ын итгэлцлээр татан төвлөрүүлэх эх үүсвэрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сулруулж, ББСБ нь тодорхой шаардлагыг зэрэг хангасан тохиолдолд эх үүсвэр татах хувь хэмжээг хувьчлан тогтоож өгөв.

- ББСБ-ууд хөрөнгийн зах зээлд гарч, нээлттэй хувьцаат компани болох, банк банк бус санхүүгийн тодорхой нэр төрлийн үйл ажиллагааг эрхлэх, олон улсаас хөрөнгө оруулалт татах, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн хэрээр нягтлан бодох бүртгэл, тайлагналыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-д нийцүүлэх, салбарын нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг шинэчлэх, зайлшгүй шаардлага үүссэн. Үүний дагуу “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд ББСБ-ууд энэхүү журмыг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Шинэчилсэн журамд СТОУС-9 Санхүүгийн хэрэглүүр, СТОУС-13 Бодит үнэ цэнийн хэмжилт, СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа зэрэг СТОУС, НББОУС-ын дагуу санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, ангилах, хэмжих, ажил гүйлгээний бүртгэлийг дэлгэрэнгүй байдлаар тусгасан.

4.2.4 Хадгаламж зээлийн хоршоо

- “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгж,

байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг Сангийн яамтай хамтран боловсруулж, Сангийн сайдын 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар баталсан. Журамд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, ангилах, хэмжих талаар Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн дэлгэрэнгүй тусгаж, эрсдэлийн санг ангилах бүртгэлийн арга хандлагыг нарийвчлан зохицуулж, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга бэлтгэх заавар, дансны жагсаалтыг шинэчилсэн. Хадгаламж, зээлийн хоршоод 2024 оны 2 дугаар улирлаас эхлэн шинэ журмын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайлангаа ирүүлж байна.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 286 дугаар тогтоолоор “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийг шинэчлэн баталж, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг олон улсын түвшинд нийцүүлж, зарим үзүүлэлтийн тооцооллыг өөрчлөв. Ингэснээр ХЗХ-дын ашигт ажиллагаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт сайжрах юм. Шинэчилсэн шалгуур үзүүлэлтүүдийг 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор хангаж ажиллахыг нийт ХЗХ-дод үүрэг болгосон.
- Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн

148 дугаар тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны дотоод хяналтын шалгах хуудасны үлгэрчилсэн загвар”-ыг баталсан. Ингэснээр хадгаламж, зээлийн хоршооны хяналтын зөвлөл шалгах хуудсыг удирдлага болгон өөрийн хадгаламж, зээлийн хоршооны эрсдэлийг тогтмол үнэлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж ажиллах боломжтой болсон.

- Хадгаламж, зээлийн хоршооны хяналтын зөвлөлийн гишүүдийг хоршоондоо “Шалгах хуудас”-ын дагуу иж бүрэн шалгалтыг жилд нэгээс доошгүй, хэсэгчилсэн шалгалтыг шаардлагатай тухай бүр хийхийг зөвлөмж болгов.

4.2.5 Виртуал хөрөнгийн зах зээл

- Санхүүгийн зохицуулах хорооноос Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ)-ийн тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-аас тус хуулийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан. Үүний дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 10 харилцааг зохицуулсан нийт 8 журмыг баталсан.
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хэрэглэгчдийн тоо, виртуал хөрөнгийн ханш, арилжааны дэлгэрэнгүй мэдээлэл зэргийг өдөр бүр API системээр хүлээн авч, хяналт тавин ажиллаж байна.

Виртуал хөрөнгийн хяналтын систем болох “Chainalysis” программыг хяналт, зохицуулалтын үйл ажиллагаандаа нэвтрүүлээ.